



Монголын Үндэсний Худалдаа Аж
Үйлдвэрийн Танхим



Бизнесийн
Сургууль



МОНГОЛЫН БИЗНЕСИЙН ОРЧНЫ СУДАЛГАА

Улаанбаатар хот
2017 он

Агуулга

УДИРТГАЛ	4
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СУДАЛГААНД ОРОЛЦОГСДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	7
ХОЁРДУГААР ХЭСЭГ. МОНГОЛЫН БИЗНЕСИЙН ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ	10
2.1 Монголын бизнесийн орчны өнөөгийн ерөнхий үнэлгээ.....	10
2.2 Бизнесийн орчны үнэлгээ, дэд үзүүлэлтүүдээр	13
2.2.1 Дэд бүтэц, технологийн орчин.....	14
2.2.2 Эдийн засгийн орчин.....	15
2.2.3 Засаглал, хууль эрх зүйн орчин	16
2.2.4 Нийгэм, соёлын орчин	17
2.2.5 Бизнесийн дотоод орчны үнэлгээ	18
2.3 Монголын бизнесийн орчны сүүлийн 3 жилийн өөрчлөлт	19
ГУРАВДУГААР ХЭСЭГ. БИЗНЕСИЙН ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ	19
3.1 Монгол улсад бизнес эрхлэхэд гардаг нийтлэг хүндрэл.....	23
3.1.1 Шинэ бизнес эхлүүлэхэд гардаг нийтлэг хүндрэл.....	23
3.1.2 Техникийн нөхцөл (зөвшөөрөл) авахад гардаг хүндрэл	25
3.1.3 Хөрөнгө бүртгүүлэхтэй холбоотой асуудал.....	27
3.1.4 Санхүүжилттэй холбоотой асуудлууд	30
3.1.5 Хувьцаа эзэмшигч/ хөрөнгө оруулагчтай холбоотой асуудал	33
3.1.6 Татвартай холбоотой асуудал.....	34
3.1.7 Бизнесийн маргаантай холбоотой асуудал.....	36
3.1.8 Дампууралтай холбоотой асуудал	37
3.2 Гадаад худалдаа эрхлэхэд гардаг нийтлэг хүндрэлийг үнэлэх.....	39
3.2.1 Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гардаг нийтлэг хүндрэл.....	39
3.2.2 Гадаад худалдааны түнш орнуудын нутаг дэвсгэр дээр гардаг нийтлэг хүндрэл.....	46
3.2.3 Гадаад худалдаа эрхлэгч ААН-н үйл ажиллагаанд гарч буй хүндрэл бэрхшээл	47
ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. БИЗНЕСИЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ	51
4.1 Төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо.....	51
4.1.1 Бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлдэг субъектийн оролцооны түвшин..	51
4.1.2 Бизнес хөгжүүлэлт дэх төрийн байгууллагын саад.....	54
4.1.3 Төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээ нь бизнест дэмжлэг болсон эсэх.....	59
4.2 Бизнесийн орчинг сайжруулах бодлого, үйл ажиллагааны хүрээнд цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ	62
4.3 Өнөөгийн Монголын бизнесийн орчны ерөнхий үнэлгээ, бизнесийн орчинг сайжруулах чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ.....	64
ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ	68

Өмнөх үг

Бизнесийн орчинг тогтмол анхааралтай ажиглаж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр шаардлагатай бодлого боловсруулан, зохих арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлж байх нь бизнес эрхлэх таатай тогтвортой орчинг бүрдүүлэхэд маш чухал билээ. Нөгөө талаас бизнестэй холбоотой бодлого, хууль эрх зүйн аливаа шийдвэрийг гаргахдаа судалгааны үр дүнд үндэслэх нь тухайн бодлого ба эрх зүйн өөрчлөлтийн үр нөлөө бизнест эерэг байх үндэс болно.

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим нь сүүлийн 20 жилийн хугацаанд бизнесийн орчинтой холбоотой судалгаануудыг тогтмол явуулж, судалгааны дүнд гарсан санал зөвлөмжийг бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт хүргэж ирсэн. Монгол улсын эдийн засгийн өсөлт саарч, гадаадын шууд хөрөнгө оруулалт буурч, бизнес эрхлэхэд хүндрэлтэй болж бизнес эрхлэгчдийн итгэх итгэл буурч байгаа өнөө үед “Triple helix” буюу төр, хувийн хэвшил, академик байгууллагуудын үр дүнтэй хамтын ажиллагаа нь энэхүү хямрал, хүндрэлээс гарах гарц шийдлийг олоход шийдвэрлэх ач холбогдолтой юм.

МҮХАҮТ-аас санаачлан МУИС-ийн Бизнесийн сургуультай хамтран Монгол улсын эдийн засаг, бизнесийн салбарын онцлогт тохирсон бизнесийн орчны судалгааг анх удаа үндэсний хэмжээнд явуулж судалгааны тайлан, үр дүнг та бүхэнд танилцуулж байна. МҮХАҮТ судалгааны дүнд гарсан асуудлуудаар оролцогч талуудтай хамтран бизнесийн орчныг сайжруулах талаар санал зөвлөмж боловсруулан Монгол Улсын Засгийн Газарт хүргүүлэх юм.

Та бүхэн судалгаатай холбоотой санал, зөвлөмжийг МҮХАҮТ-ын Бодлого судалгаа хөгжлийн газарт хаяглан ирүүлнэ үү.

МҮХАҮТ-ын орлогч дарга М.Сарандаваа

УДИРТГАЛ

Судалгааг хийх үндэслэл

Үндэсний баялгыг бүтээдэг бизнес эрхлэгчдийн үргэлж сонирхдог асуулт нь бид ямар орчинд бизнес эрхэлж байна, энэ орчин нь цаашид яаж өөрчлөгдөх бол, хир тогтвортой байх вэ? гэсэн асуултууд байдаг. Бизнес эрхлэх орчинг таатай, тогтвортой байлгах нь төрийн бодлогын үндсэн чиг үүрэг бөгөөд тэрхүү бодлого нь ул суурьтай, бодит судалгааны үр дүнд үндэслэгдэх нь нэн чухал юм.

Хэдийгээр олон улсын түвшинд Doing Business зэрэг бизнес эрхлэхтэй холбоотой судалгаанууд явагддаг боловч эдгээр судалгаа нь улс орнуудын нийтлэг шаардлагад үндэслэн хийгддэг учраас тухайн орны өвөрмөц онцлог шинжийг бүрэн агуулаагүй байдаг. Иймээс улс орнууд өөрийн орны бизнесийн орчныг тусгайлан судалсны үндсэн дээр бизнес эрхлэх таатай орчныг бий болгох төрийн бодлогыг оновчтой явуулах замаар бизнес эрхлэгчдийг дэмжих хэрэгцээ шаардлага байсаар байна.

Судалгааны зорилго:

Монгол улсын бизнесийн орчны өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх, бизнесийн орчныг сайжруулах боломжийг тодорхойлоход энэхүү судалгааны зорилго оршино.

Судалгааны зорилт:

- ✓ Бизнесийн орчинд нөлөөлөх хүчин зүйлсийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийх
- ✓ Бизнесийн орчныг сайжруулахад нэн тэргүүн хэрэгжүүлэх арга хэмжээ, эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагын үүрэг оролцоог тодорхойлох

Судалгааны арга зүй, арга

Судалгаанд тоон судалгааны аргачлалыг ашиглан, статистик шинжилгээ, харьцуулалт, корреляцийн шинжилгээ, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх болон түүвэр судалгааны аргуудыг ашиглав.

Судалгааны мэдээлэл боловсруулалт

Түүвэр судалгааны мэдээлэл цуглуулалтыг үндэсний хэмжээнд буюу 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргээс 2016 оны 11, 12 сард авч үр дүнг улсын хэмжээнд болон бүсийн түвшинд (баруун, хангайн, төв, зүүн бүс болон Улаанбаатар хот) гаргасан болно. Судалгааны түүвэрлэлтийг хийхдээ Баруун бүсийн 5 аймаг тус бүрээс 75, Хангайн болон Зүүн бүсийн 9 аймаг тус бүрээс 70, Төвийн бүсийн 7 аймаг тус бүрээс 60, Улаанбаатар хотын 9 дүүрэг тус бүрээс 65, нийт 2010 аж ахуйн нэгжээс судалгааг авсан ба шаардлага хангасан 1573 аж ахуй нэгжийн судалгааг STATA, SPSS программаар боловсруулалт хийж үр дүнг дээр дурдсан 5 бүс болон улсын дунджаар харьцуулан гаргасан болно.

Судалгааны агуулга

Судалгаа үндсэн 4 хэсэгтэй ба нэгдүгээр хэсэгт судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл, хоёрдугаар хэсэгт бизнесийн орчинд нөлөөлөх хүчин зүйлсийн ерөнхий үнэлгээ, гуравдугаар хэсэгт бизнесийн орчинд нөлөөлөх хүчин зүйлсийн нарийвчилсан үнэлгээ, дөрөвдүгээр хэсэгт бизнесийн орчныг сайжруулах асуудлыг тус тус авч үзсэн.

Талархал

Энэхүү судалгаанд идэвхитэй оролцож үнэтэй санал зөвлөгөө өгсөн нийт аж ахуйн нэгж байгуулагууд, орон нутаг дахь ХАҮТ болон Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газарт Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим болон МУИС-ийн Бизнесийн Сургуулийн судалгааны багийн хамт олноос гүн талархал илэрхийлье.

Судалгааг гүйцэтгэсэн багийн бүрэлдэхүүн

Судалгааны багийн ахлагч

- Доктор Б.Даваасүрэн (МУИС-ийн Бизнесийн Сургуулийн Сургалтын албаны эрхлэгч, профессор)

Гишүүд

- Доктор М.Должин (МУИС-ийн Бизнесийн Сургуулийн дэд захирал, профессор)
- Доктор Н.Отгонсайхан (МУИС-ийн Бизнесийн Сургуулийн Маркетинг, Худалдааны тэнхмийн эрхлэгч, профессор)
- Доктор Д.Энх-Отгон (МУИС-ийн Бизнесийн Сургуулийн Менежментийн тэнхмийн багш, дэд профессор)
- МҮХАҮТ-ын Бодлого Судалгаа Хөгжлийн газрын мэргэжилтэн О.Түмэн-Амар

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СУДАЛГААНД ОРОЛЦОГСДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд хамрагдсан 1573 аж ахуйн нэгж (ААН)-ийг үйл ажиллагааны чиглэлээр нь ангилж үзвэл 46% нь худалдаа, 21% нь үйлчилгээ, 14% нь боловсруулах үйлдвэрлэл, үлдэх 20% нь бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна.


Хүснэгт 1.1 Судалгаанд хамрагдсан ААН-н үйл ажиллагаа явуулж буй чиглэл (бүс нутгаар, хувиар)

№	Бизнесийн төрөл	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар хот	Нийт
1	Худалдаа	49	44	39	43	52	46
2	Үйлчилгээ	19	20	26	22	17	21
3	Боловсруулах үйлдвэрлэл	17	14	15	14	10	14
4	Барилга	4	3	2	5	6	4
5	Мал аж ахуй	3	3	4	4	1	3
6	Газар тариалан	3	5	4	3	1	3
7	Мэдээллийн технологи, харилцаа холбоо	1	1	2	2	2	2
8	Аялал жуулчлал	1	2	1	1	2	2
9	Уул уурхай	1	2	1	1	3	2
10	Тээвэр	1	1	1	1	2	1
11	Бусад	0	4	4	2	4	3
12	Нийт	100	100	100	100	100	100

Судалгаанд худалдааны салбарт жижиглэн худалдаа, үйлчилгээний салбарт зочид буудал нийтийн хоол, боловсруулах үйлдвэрийн салбарт хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд зонхилон хамрагдсан байна.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн хэлбэр

Зураг 1.1 Аж ахуйн нэгжийн хэлбэр (бүс нутгаар, хувиар)




Судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 66.1% нь хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК), 19.3% иргэд бол үлдэх 14.6% нь хувьцаат компани (ХК), нөхөрлөл, хоршоо байна. Бүс хоорондыг харьцуулахад хоршоо болон нөхөрлөл хэлбэрийн аж ахуйн нэгж баруун бүсээс, иргэн (30.4%) хангайн бүсээс хамгийн их хамрагдсан.

Аж ахуйн нэгжийн өмчлөлийн хэлбэр

Судалгаанд хамрагдсан ААН-н дийлэнх буюу 95.8% нь хувийн хэвшлүүд бол үлдэх 4.2% нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн оролцоотой ААН байна.

Зураг 1. 2 ААН-ийн өмчлөлийн хэлбэр (хувиар)



Түүнчлэн судалгаанд хамрагдсан ААН-ийн өмчлөлийн хэлбэрийг үйл ажиллагаа явуулж буй салбараар нь харьцуулан үзвэл төрийн өмчит ААН-ийн хувьд Уул уурхайн салбарт, төрийн оролцоотой ААН тээврийн салбарт илүүтэйгээр хамрагджээ.

Аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтын хэлбэр

Судалгаанд 1349 ААН энэ асуултанд хариулсан ба тэдний 96.4% нь дотоодын хөрөнгө оруулалттай байна. Бүсээр авч үзвэл гадаадын хөрөнгө оруулалттай ААН нь Улаанбаатар хотод 6.6% хамрагдсан нь бусад бүстэй харьцуулахад өндөр юм.

Хүснэгт 1.2 ААН-ийн хөрөнгө оруулалтын хэлбэр (бүс нутгаар, хувиар)


Хөрөнгө оруулалтын хэлбэр	Улсын дүн	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар
Дотоодын	96.4	96.8	97.2	97.3	99.3	93.4
Гадаадын	3.6	3.2	2.8	2.7	0.7	6.6

Аж ахуйн нэгжийг хэмжээгээр нь ангилахдаа Монгол улсын “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хууль болон бусад хууль тогтоомжуудыг тулгуур болгон “ажиллагсдын тоо”-г үндэслэн дараах байдлаар ангилсан болно. Үүнд:

- 1-19 ажиллагсадтай аж ахуйн нэгжийг: Жижиг
- 20-199 ажиллагсадтай аж ахуйн нэгжийг: Дунд
- 200-с дээш тооны ажиллагсадтай аж ахуйн нэгжийг: Том.


Судалгаанд хамрагдсан 10 ААН тутмын 7 нь 2010 оноос өмнө, 3 нь 2010 оноос хойш үүсгэн байгуулагдсан бол 8 нь жижиг дунд бизнес эрхлэгчид байна. Жилийн борлуулалтын орлогын хувьд 43% нь 100 саяас бага, 34% нь 101-400 сая, 16% нь 401-1000 сая, 7% нь 1 тэрбум төгрөгнөөс дээш борлуулалтын орлоготой компаниуд байв.

Зураг 1.3 ААН-н үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа (хэмжээ, хувиар)



Судалгаанд хамрагдсан ААН-н зээлийн санхүүжилтийг авч үзэхэд 10 ААН-н 8 нь зээлийн үлдэгдэлтэй бөгөөд тэдний дийлэнх нь эргэлтийн хөрөнгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Үүнийг бүсээр тодруулбал Төвийн бүсэд зээлийн үлдэгдэлтэй ААН-н эзлэх хувь хэмжээ хамгийн их буюу 82.5% байгаа бол Улаанбаатар хотод хамгийн бага буюу 69.6% байна. Хэдийгээр Улаанбаатар хотын хувьд зээлийн үлдэгдэлгүй ААН-н эзлэх хувь хэмжээ бусад бүстэй харьцуулахад харьцангуй өндөр байгаа ч эргэлтийн болон үндсэн хөрөнгийн гэсэн хавсарсан зээлтэй ААН (21.2%) их байна.

Зураг 1.4 ААН-н зээлийн үлдэгдэлтэй эсэх (бүс нутгаар, хувиар)



ХОЁРДУГААР ХЭСЭГ. МОНГОЛЫН БИЗНЕСИЙН ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

2.1 Монголын бизнесийн орчны өнөөгийн ерөнхий үнэлгээ

Монголын бизнесийн орчны ерөнхий үнэлгээг 5 ерөнхий, 12 дэд бүлгийн 88 асуулгаар 1-7 онооны үнэлгээгээр үнэлүүлж үр дүнг гаргалаа. Үнэлгээний коэффициентийг тодорхойлохдоо жигнэсэн дунджийн аргыг ашигласан бөгөөд энэ нь асуултанд хариулагсдын тоог харгалзуулж дундаж утгаар тооцоологдсон учраас энгийн дунджийн аргаас илүү нарийвчлалтайгаар тооцоологдов. Тоогоор илэрхийлж буй үнэлгээнд харгалзах утга нь дараах байдалтай болно.

1-Маш муу (Нэн яаралтай арга хэмжээ авах шаардлагатай)

2-Муу (Яаралтай арга хэмжээ авах шаардлагатай)

3-Хангалтгүй (Яаралтай арга хэмжээ авах зүйл бага ч анхаарах шаардлагатай)

4-Дунд (Асуудал харьцангуй бага)

5-Хангалттай (Санаа зовох зүйл ойрын үед байхгүй)

6-Сайн (Санаа зовох зүйл ер нь байхгүй)

7-Маш сайн (Огт асуудал байхгүй)


Хүснэгт 2.1 Монголын бизнесийн орчны үнэлгээ (ерөнхий үзүүлэлтүүдээр)

Д/д	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ОРЧНЫ ҮНЭЛГЭЭНИЙ КОЕФФИЦИЕНТ	БОЛОМЖИТ ДЭЭД УТГА
1	Дэд бүтэц, технологи	3.43	7
2	Бизнесийн байгууллагын үйл ажиллагаа	3.37	7
3	Эдийн засгийн орчин	2.96	7
4	Нийгэм, соёл	2.93	7
5	Засаглал, хууль эрх зүй	2.69	7
	Үнэлгээний дундаж	3.03	

Бизнесийн орчны дундаж үнэлгээ нь хангалтгүй буюу 3.03 гарсан нь яаралтай арга хэмжээ авах зүйл бага ч, анхаарах шаардлагатай гэсэн хариулттай дүйж байна. Эдийн засаг, нийгэм соёл, засаглал, хууль эрхзүйн орчны үзүүлэлтүүдэд муу буюу яаралтай арга хэмжээ авах шаардлагатай гэсэн үнэлгээг өгчээ. Эдгээр нь санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаа доголдолтой, засгийн газрын институцийн тогтолцооны уялдаа холбоо муу болон хүн амын худалдан авах чадвар муу гэсэн үнэлгээнээс хамаарсан байна.

Боломжит дээд утга болох 7 оноотой харьцуулбал ерөнхий орчны үнэлгээ нь дунджаараа тал хувьд нь хүрсэн үнэлгээ нэг ч байхгүй байгаа нь Монголын бизнесийн орчин туйлын хангалтгүй түвшинд байгааг илтгэж байна.

Зураг 2.1 Монголын бизнесийн орчны үнэлгээ (ерөнхий үзүүлэлтүүдээр)



Монголын бизнесийн орчны үнэлгээний зураглал нь боломжит дээд утгаасаа орчны бодит үнэлгээ нь эзэлж буй талбайн хувьд хэд дахин бага байна. Энэ нь бизнесийн чадамжийн хувьд өчүүхэн зайнд манай бизнес эрхлэгчид үйл ажиллагаа явуулж буйг илтгэнэ.

Хүснэгт 2.2 Монголын бизнесийн орчны үзүүлэлтүүдийн хоорондын хамаарал

Үзүүлэлтүүд		Дэд бүтэц, технологи	Эдийн засгийн орчин	Засаглал, хууль эрх зүй	Нийгэм, соёл	Бизнесийн байгууллагын үйл ажиллагаа	Бизнесийн ерөнхий үнэлгээ
Дэд бүтэц, технологи	Pearson Correlation	1					
Эдийн засгийн орчин	Pearson Correlation	.580**	1				
Засаглал, хууль эрх зүй	Pearson Correlation	.508**	.749**	1			
Нийгэм, соёл	Pearson Correlation	.410**	.540**	.633**	1		
Бизнесийн байгууллагын үйл ажиллагаа	Pearson Correlation	.449**	.534**	.529**	.545**	1	
Бизнесийн ерөнхий үнэлгээ	Pearson Correlation	.199**	.278**	.317**	.277**	.242**	1

** . Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

Монголын бизнесийн орчны үзүүлэлтүүдийн хоорондын хамаарлыг корреляцийн шинжилгээ хийж харвал бизнесийн ерөнхий үнэлгээнд засаглал, хууль эрх зүйн үзүүлэлт ($K=0.317^{**}$, $P<0.01$) хамгийн их нөлөөтэй гэсэн үр дүн гарч байна. Үүний дараагаар эдийн засаг ($K=0.278^{**}$, $P<0.01$), нийгэм соёлын ($K=0.277^{**}$, $P<0.01$) хүчин зүйлс бизнесийн ерөнхий үнэлгээнд хүчтэй нөлөөлсөн байна.

Монголын бизнесийн орчны ерөнхий үнэлгээг бүс нутгийн ангилалаар нэгтгэн дундаж үнэлгээг дараах байдалтайгаар тодорхойлон харуулав.


Хүснэгт 2.3 Монголын бизнесийн орчны үнэлгээ (бүс нутгаар, дундаж коэффициент)

Үзүүлэлтүүд	Дэд бүтэц, технологи	Эдийн засгийн орчин	Засаглал, хууль эрх зүй	Нийгэм, соёл	Бизнесийн байгууллагын үйл ажиллагаа	Дундаж үнэлгээ
Төвийн бүс	3.82	3.23	2.98	3.26	3.69	3.40
Зүүн бүс	3.57	2.90	2.92	3.03	3.33	3.15
Хангайн бүс	3.46	2.86	2.69	2.94	3.36	3.06
Баруун бүс	3.20	2.94	2.77	2.80	3.13	2.97
Улаанбаатар хот	3.17	2.77	2.38	2.68	3.32	2.87

Төвийн бүсийн аймгуудын бизнесийн орчны үзүүлэлтүүд нь бусад бүс нутгуудтайгаа харьцуулахад аль ч талаараа илүү таатай гэсэн хариултууд өгөгдсөн бол Улаанбаатар хотын бизнес эрхлэгчид бизнесийн байгууллагын дотоод үйл ажиллагаанаас бусад үзүүлэлтүүдээр хамгийн тааруу гэсэн үнэлгээг тус тус өгчээ. Энэ нь нийслэлд бизнесийн үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдийн бизнесийн орчин нь илүү таагүй байгааг тодорхойлж байна.

Бүс нутгуудыг ерөнхий 5 орчны үзүүлэлтүүдээр нь боломжит дээд утга болох 7 оноотой харьцуулан зураглалаар харвал дараах байдалтай байна.

Зураг 2.2 Монголын бизнесийн орчны үнэлгээ, бүс нутгаар



Эдгээр зураглалаас харвал бизнесийн орчны өнөөгийн үнэлгээ нь боломжит дээд утгатайгаа харьцуулахад маш бага талбай эзэлж байгаа бөгөөд аль ч үзүүлэлтээрээ хангалттай түвшинд хүрээгүй. Ялангуяа Улаанбаатар хот болон баруун бүсийн аймгуудын бизнесийн орчны хүрээ нь туйлын хангалтгүй түвшинд байна гэсэн хариултыг өгчээ.

Монголын бизнесийн орчны үнэлгээг хийхдээ ААН-ийг хэмжээгээр ангилан тус тусын үнэлгээ болон орчны үзүүлэх нөлөөлөл талаас нь судалсан болно.

Хүснэгт 2.5 Монголын бизнесийн орчны үнэлгээ (ААН-н хэмжээгээр, дундаж коэффициент, дээд утга 7)

Үзүүлэлтүүд		Дэд бүтэц, технологи	Эдийн засаг	Засаглал, хууль эрх зүй	Нийгэм, соёл	Бизнесийн байгууллагын үйл ажиллагаа	Нийт
Жижиг аж ахуйн нэгжүүд	Үнэлгээ	3.44	2.95	2.76	2.97	3.33	3.09
Дунд аж ахуйн нэгжүүд	Үнэлгээ	3.39	2.88	2.61	2.79	3.50	3.04
Том аж ахуйн нэгжүүд	Үнэлгээ	3.62	3.23	2.81	2.98	4.30	3.39
Улсын дундаж	Үнэлгээ	3.48	3.02	2.73	2.91	3.71	3.17

Судалгаанд оролцогсад ерөнхийдөө бизнесийн орчинг хангалтгүй гэж үнэлсэн бөгөөд үүний дотор дунд хэмжээний бизнес эрхлэгчдийн дийлэнх нь туйлын хангалтгүй гэж үнэлсэн.

2.2 Бизнесийн орчны үнэлгээ (дэд үзүүлэлтээр)

Бизнесийн орчны үндсэн 5 үзүүлэлтийн үнэлгээг тус бүрээр нарийвчлан тодорхойлохыг зорив.

Хүснэгт 2.6 Монголын бизнесийн орчны өнөөгийн үнэлгээ (голлох үзүүлэлтүүдээр)

Д/Д	Үзүүлэлтүүд	Үнэлгээний коэффициент
1	Дэд бүтэц, технологи	3.43
1.1	Үндсэн дэд бүтэц	3.43
1.2	Технологи, харилцаа холбоо	3.43
2	Эдийн засгийн орчин	2.96
2.1	Татварын орчин	2.94
2.2	Санхүүгийн зах зээл	2.65
2.3	Хүний нөөцийн хомсдол, ажиллах хүч	3.25
3	Засаглал, хууль эрх зүй	2.69
3.1	Засгийн газрын институцийн тогтолцоо, уялдаа холбоо	2.53
3.2	Бизнесийн эрхзүйн орчин	3.12
3.3	Засгийн газрын үйл ажиллагаа	2.53
4	Нийгэм, соёл	2.93
4.1	Нийгмийн хандлага	3.30
4.2	Хүн ам зүй	2.57
5	Бизнесийн байгууллагын үйл ажиллагаа	3.37
5.1	Удирдлага, зохион байгуулалт	3.43
5.2	Байгууллагын үр ашиг, бүтээмж	3.32
	Үнэлгээний дундаж	3.03

2.2.1 Дэд бүтэц, технологийн орчин

Дэд бүтэц, технологийн орчныг үндсэн дэд бүтэц, технологи харилцаа холбоо гэсэн 2 бүлэг үзүүлэлтүүдээр үнэлэв.

Хүснэгт 2.7 Дэд бүтэц, технологийн орчны үнэлгээ (дэд үзүүлэлтүүдээр, дундаж коэффициент дээд утга 7)

Үзүүлэлтүүд	Дундаж үнэлгээний коэф	Үзүүлэлтүүд	Дундаж үнэлгээний коэф
Үндсэн дэд бүтцийн үзүүлэлтүүд		Технологи, харилцаа холбооны орчны үзүүлэлтүүд	
Эрчим хүч	4.103	Интернетийн хэрэглээний боломж	4.176
Усны нөөц, хүртээмж	3.804	Шуудан харилцааны хэрэглээний боломж	4.133
Агаарын тээвэр	3.583	Патент, барааны тэмдэг эзэмшихэд хялбар байдал	3.317
Автозам	3.532	Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагатай хамтарч ажиллах боломж	3.202
Төмөрзам	3.53	Дэвшилтэт технологийн нэвтрүүлэлт, зохицуулалт	2.96
Бүтээгдэхүүн түгээлтийн сүлжээ	3.342	Засгийн газрын техник, технологийн тусламж, дэмжлэг	2.717
Автозамын засвар үйлчилгээ	3.185		
Шатахуун, түлшний үнэ	3.105		
Далайн гарц	2.531		
Үнэлгээний дундаж	3.43	Үнэлгээний дундаж	3.43

Үндсэн дэд бүтцийн үзүүлэлтүүдээс эрчим хүчний үзүүлэлт нь дунд буюу асуудал харьцангуй бага, харин далайн гарцын хувьд муу буюу яаралтай арга хэмжээ авах шаардлагатай, үлдсэн үзүүлэлтүүд нь хангалтгүй гэж дүгнэгджээ. Монгол улсын хувьд далайд гарцгүй учраас үүнийг орлохуйц, улсынхаа онцлогийг харгалзсан, үр ашиг бүхий дэд бүтцийн системийг бий болгох шаардлагатайг судалгаанд оролцогсад онцолсон. Технологи, харилцаа холбооны үзүүлэлтүүдээс интернет хэрэглээний боломж болон шуудан харилцааны хэрэглээний боломж үзүүлэлтүүд нь дунд буюу асуудал харьцангуй бага, харин засгийн газрын техник технологийн тусламж дэмжлэг болон дэвшилтэт технологийн нэвтрүүлэлт, зохицуулалт үзүүлэлтүүдийн хувьд муу буюу яаралтай арга хэмжээ авах шаардлагатай, үлдсэн үзүүлэлтүүд нь хангалтгүй гэж үнэлэгджээ. Иймд дэвшилтэт техник, технологийн асуудал дээр засгийн газар болон бизнес эрхлэгчдийн зүгээс аль аль нь анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

2.2.2 Эдийн засгийн орчин

Эдийн засгийн орчинг татвар, санхүүгийн зах зээл, хүний нөөцийн хомсдол ажиллах хүч гэсэн 3 бүлэг үзүүлэлтүүдээр үнэлсэн.

Татварын орчны үзүүлэлтүүдэд санал асуулгад оролцогсад муу гэсэн үнэлгээг өгсөн. Үүнээс нийтээрээ татвар төлж буй эсэх (татварын суурь), татварын урамшуулал, НӨАТ-ын хувь хэмжээ, татварын давхардалт зэрэг үзүүлэлт муу буюу яаралтай арга хэмжээ авах шаардлагатай гэж үнэлсэн. Энэ нь татвар ноогдуулалт тэгш бус тогтоогдсон болон татварын суурь нь албан ёсны аж ахуйн нэгжүүдийнхээс л бүрддэг, албан бус бизнес эрхлэгчдээс бага татвар авдаг эсвэл бодит амьдрал дээр огт авдаггүй зэрэг нь шударга бус өрсөлдөөнийг үүсгэдэг зэргээс улбаатай үнэлгээ юм.

Хүснэгт 2.8 Эдийн засгийн орчны үнэлгээ (дэд үзүүлэлтүүдээр, дундаж коэффициент)

Үзүүлэлтүүд	Дундаж үнэлгээ (дээд утга 7)	Үзүүлэлтүүд	Дундаж үнэлгээ (дээд утга 7)	Үзүүлэлтүүд	Дундаж үнэлгээ (дээд утга 7)
Татварын орчны үнэлгээний үзүүлэлтүүд		Санхүүгийн зах зээлийн орчны үнэлгээний үзүүлэлтүүд		Хүний нөөцийн хомсдол, ажиллах хүчний үзүүлэлтүүд	
Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хувь хэмжээ	3.11	Банк, санхүүгийн үйлчилгээний төрөл	3.32	Хүний нөөц хомсдолтой эсэх	3.26
Татвар төлөлтөнд зарцуулах хугацаа	3.10	Хувь нийлүүлэгчдийн эрх	2.91	Хөдөлмөрийн харилцааны эрх зүйн зохицуулалт	3.25
Нийгмийн даатгалын шимтгэл	3.09	Зээл авахад хялбар байдал	2.81	Ажиллах хүчний мэдлэг, ур чадварын түвшин	3.24
Бусад албан татварын хувь хэмжээ	3.06	Хөрөнгийн зах зээлд оролцох боломж	2.69	Үнэлгээний дундаж	3.25
Гаалийн албан татварын хувь хэмжээ	2.97	Дотогш чиглэсэн хөрөнгө оруулалт	2.55		
Онцгой албан татварын хэмжээ	2.96	Хөрөнгө оруулалтын урамшууллын бодлого	2.38		
Татварын төрлийн тоо	2.96	Зээлийн хүүгийн хувь хэмжээ	2.31		
ХАОАТ-ын хувь хэмжээ	2.95	Мөнгөний ханшны хэлбэлзлийн бизнес дэх нөлөөлөл	2.24		

Орлогын албан татварын хувь хэмжээ	2.93	Үнэлгээний дундаж	2.65
Татварын давхардалт	2.84		
НӨАТ-ын хувь хэмжээ	2.83		
Татварын урамшуулал	2.76		
Нийтээрээ татвар төлж буй эсэх (татварын суурь)	2.70		
Үнэлгээний дундаж	2.94		

Санхүүгийн зах зээлийн үзүүлэлтүүдийг судалгаанд оролцогсад ерөнхийд нь муу гэж үнэлсэн. Банк, санхүүгийн үйлчилгээний төрлөөс бусад бүх үзүүлэлтүүд, тэр дундаа мөнгөний ханшны хэлбэлзлийн бизнес дэх нөлөөлөл, зээлийн хүүгийн хувь хэмжээ, хөрөнгийн зах зээлд оролцох боломж, хөрөнгө оруулалтын урамшууллын бодлого, дотогш чиглэсэн хөрөнгө оруулалт гэсэн үзүүлэлтүүд нь муу буюу яаралтай арга хэмжээ авах шаардлагатай гэж үнэлэгдсэн. Мөнгөний ханшны хэлбэлзэл өндөр савалгаатай, бизнес эрхлэгчдэд банкнаас олгож буй зээлийн хүүгийн хэмжээ маш өндөр, хөрөнгийн зах зээлийн хөгжил сул дорой, дотоодын хөрөнгө оруулагчдад дэмжлэг төдийлөн байдаггүй зэрэг нь Монголын бизнес эрхлэгчдэд хүндээр тусч буй нь тодорхой байна.

Хүний нөөцийн хомсдол, ажиллах хүчний үзүүлэлтүүд нь анхаарах шаардлагатай хэмээн үнэлэгдсэн хэдий ч дэд үзүүлэлтүүдээс ажиллах хүчний мэдлэг, ур чадварын түвшин доогуур үнэлэгдсэн нь өнөөгийн хөдөлмөрийн зах зээлд ажил олгогчдын шаардлагад нийцсэн хүний нөөцийг бэлтгэх асуудалд анхаарах шаардлагатайг илтгэж байна.

2.2.3 Засаглал, хууль эрх зүйн орчин

Засаглал, хууль эрх зүйн орчныг засгийн газрын институцийн тогтолцоо уялдаа холбоо, бизнесийн эрхзүйн орчин, засгийн газрын үйл ажиллагаа гэсэн 3 бүлэг үзүүлэлтүүдээр үнэлсэн.

Хүснэгт 2.9 Засаглал, хууль эрх зүйн орчны үнэлгээ (дэд үзүүлэлтүүдээр, дундаж коэффициент)

Үзүүлэлтүүд	Дундаж үнэлгээ (дээд утга 7)	Үзүүлэлтүүд	Дундаж үнэлгээ (дээд утга 7)	Үзүүлэлтүүд	Дундаж үнэлгээ (дээд утга 7)
Засгийн газрын институцийн тогтолцоог үнэлэх үзүүлэлтүүд		Бизнесийн эрх зүйн орчны үнэлгээний үзүүлэлтүүд		Засгийн газрын үйл ажиллагааны үнэлгээний үзүүлэлтүүд	
Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин	2.66	Компанийн тухай хууль	3.35	Хувь хүний аюулгүй байдал, хувийн өмч хамгаалагдсан байдал	2.815

Төр засгийн байгууллагуудын уялдаа холбоо	2.56	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль	3.18	Төр, хувийн хэвшлийн түншлэл	2.736
Төрийн бодлого, шийдвэрийн оновчтой байдал	2.56	Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль	3.17	Засгийн газрын татаасын зохистой байдал	2.583
Бараа бүтээгдэхүүнээ экспортлох болон гадаад зах зээлд маркетинг хийхэд засгийн газрын дэмжлэгтэй эсэх	2.55	Гэмт хэрэг, аюулгүй байдал	3.14	Бизнес эрхлэх газар эзэмшихэд хялбар байдал	2.553
Төрийн бодлого, хэрэгжүүлэлтийн тогтвортой байдлын бизнес дэх нөлөөлөл	2.48	Бизнес эрхлэхтэй холбоотой бусад хууль	3.12	Төрийн үйл ажиллагаанд тавигдах хөндлөнгийн хяналт	2.514
Төрийн эдийн засгийн бодлого нь бизнесээ дэмжиж буй байдал	2.47	Шударга бус өрсөлдөөний тухай хууль	3.12	Засгийн газрын хэрэглээ нь үндэсний үйлдвэрлэлээ дэмждэг эсэх	2.513
Үр ашигтай, дэмжлэг үзүүлж чадахуйц аж үйлдвэржилтийн хүчтэй засаглалтай эсэх	2.44	Бизнесээ зогсооход хялбар эсэх (дампуурлаа зарлахад)	3.11	Засгийн газрын үйл ажиллагааны ил тод байдал	2.505
Үнэлгээний дундаж	2.531	Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль	3.09	Төрийн албан хаагчдын хүнд суртал	2.478
		Байгаль орчны зохицуулалт	3.077	Төрийн албан хаагчдын авилгал, хээл хахууль	2.435
		Бизнесийн маргааныг шийдвэрлэх байдал	3.041	Төрийн байгууллагуудын тендерүүд шударга явагддаг эсэх	2.383
		Хуулийг дагаж мөрдүүлэх журмуудын зүй зохистой байдал	2.951	Засгийн газрын тогтвортой байдал	2.306
		Үнэлгээний дундаж	3.12	Үнэлгээний дундаж	2.529

Засгийн газрын институцийн тогтолцооны бүхий л үзүүлэлтүүдийг муу буюу яаралтай арга хэмжээ авах шаардлагатай хэмээн судалгаанд оролцогсдын ихэнх хувь нь үнэлжээ. Энэ нь бизнес эрхлэгчид болон Засгийн газрын институцийн тогтолцооны уялдаа холбоо муу, оновчтой бус байгааг харуулж байна. Ялангуяа үр ашиг бүхий дэмжлэг үзүүлж чадахуйц аж үйлдвэржилтийн хүчтэй засаглалтай эсэх, төрийн эдийн засгийн бодлого нь бизнесээ дэмжиж буй байдал, төрийн бодлого болон хэрэгжүүлэлтийн тогтвортой байдлын бизнес дэх нөлөөлөл зэрэг үзүүлэлтүүд нь маш муу үнэлгээтэй гарсныг онцгой анхаарах шаардлагатай.

Бизнесийн эрх зүйн орчны үзүүлэлтүүд нь бусад дэд үзүүлэлтүүдтэй харьцуулахад асуудал багатай хэдий ч тэдгээрээс хуулийг дагаж мөрдүүлэх журмуудын зүй зохистой байдал үзүүлэлт нь харьцангуй муу үнэлэгдсэнийг анхаарвал зохилтой.

Засгийн газрын үйл ажиллагааны бүх үзүүлэлтэд муу буюу яаралтай арга хэмжээ авах шаардлагатай гэсэн үнэлгээг өгсөн байна. Тэдгээрээс нэн ялангуяа Засгийн газрын тогтвортой байдал, төрийн байгууллагуудын тендерүүд шударга явагддаг эсэх, төрийн албан хаагчдын авилгал, хээл хахууль, төрийн албан хаагчдын хүнд суртал зэрэг нь Монголын бизнесийн орчинд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс болохыг онцгойлон тодотгосон байна.

2.2.4 Нийгэм, соёлын орчин

Нийгэм, соёлын орчинг нийгмийн хандлага болон хүн ам зүй гэсэн 2 бүлэг үзүүлэлтүүдээр үнэлсэн.

Судалгаанд хамрагдагсад хэрэглэгчдийн үндэсний соёлын өв уламжлалаа эрхэмлэн дээдэлдэг байдлыг дундаж түвшинд байдаг хэмээн үнэлсэн нь нийгмийн хандлагын үзүүлэлтүүдээс хамгийн өндөр нь юм. Харин байгальд ээлтэй ногоон технологийг бизнест нэвтрүүлэлтийн хувьд яаралтай арга хэмжээ авах зүйл бага ч анхаарах шаардлагатай хэмээн үзжээ.

Хүснэгт 2.10 Нийгэм соёлын орчны үнэлгээ (дэд үзүүлэлтүүдээр, дундаж коэффициент)

Үзүүлэлтүүд	Дундаж үнэлгээ (дээд утга 7)	Үзүүлэлтүүд	Дундаж үнэлгээ (дээд утга 7)
Нийгмийн хандлага үнэлгээний үзүүлэлтүүд		Хүн ам зүйн орчны үзүүлэлтүүд	
Үндэсний соёлын өв уламжлалаа дээдэлдэг эсэх	3.501	Дундаж давхаргын өсөлт	2.644
Хэрэглэгчид үндэсний үйлдвэрлэлээ дэмждэг эсэх	3.255	Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал	2.552
Байгальд ээлтэй ногоон технологи нэвтрүүлэлт	3.128	Хүн амын худалдан авах чадвар	2.516
Үнэлгээний дундаж	3.29	Үнэлгээний дундаж	2.57

Харин хүн ам зүйн орчны бүх үзүүлэлтэд муу буюу яаралтай арга хэмжээ авах шаардлагатай гэсэн үнэлгээг санал асуулгад оролцогсод өгчээ. Энэ нь эдийн засгийн өсөлт удааширсантай холбоотойгоор хүн амын хөдөлмөр эрхлэлт буурч, үүнээс улбаалан дундаж давхаргын өсөлт саарсан, хүн амын бодит худалдан авах чадвар буурсантай холбоотой.

2.2.5 Бизнесийн дотоод орчны үнэлгээ

Бизнесийн дотоод орчин буюу байгууллагын үйл ажиллагааны орчинг байгууллагын удирдлага, зохион байгуулалт болон үр ашиг, бүтээмж гэсэн 2 бүлэг үзүүлэлтүүдээр үнэлсэн.

Бизнесийн дотоод орчинд өгсөн үнэлгээг макро орчинд өгсөн үнэлгээтэй харьцуулахад харьцангуй асуудал багатай байдлаар үнэлэгджээ. Тодотговол байгууллагын удирдлага, зохион байгуулалтын үзүүлэлтүүдийн үнэлгээнээс Монголын компаниудын нийгмийн хариуцлага нэмэгдэж, ажиллагсадынхаа мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд анхаардаг байдал харьцангуй сайн болох нь харагдаж байна. Харин бизнесийн байгууллага, их дээд сургууль сургалт эрдэм шинжилгээний байгууллага хоорондын хамтын ажиллагаа хангалттай бус байгааг судалгаанаас харж болно.

Хүснэгт 2.11 Бизнесийн дотоод орчны үнэлгээ (дэд үзүүлэлтүүдээр, дундаж коэффициент)

Үзүүлэлтүүд	Дундаж үнэлгээ (дээд утга 7)	Үзүүлэлтүүд	Дундаж үнэлгээ (дээд утга 7)
Байгууллагын удирдлага, зохион байгуулалтын үзүүлэлтүүд		Байгууллагын үр ашиг, бүтээмжийн үнэлгээний үзүүлэлтүүд	
Компанийн нийгмийн хариуцлага сайн эсэх (Хүний эрх, хөдөлмөр эрхлэлт, авилга, байгаль орчин г.м)	3.628	Хөдөлмөрийн бүтээмж (Нийт борлуулалт/Хөдөлмөрийн зардал)	3.471
Ажиллагсадын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд анхаардаг эсэх (сургалтанд хамруулах, туршлага судлуулах г.м)	3.503	Нийт бүтээмж (Нийт борлуулалт/Нийт зардал)	3.426
Бизнесийн үйл ажиллагаандаа зохицсон оновчтой удирдлага, зохион байгуулалтын бүтэцтэй эсэх	3.432	Дэвшилтэт техник, технологи нэвтрүүлдэг эсэх	3.352
Компанийн засаглал сайн эсэх (ТУЗ, ТУЗ-ын дэд хороо)	3.427	Бизнесийг хэвийн эрхлэхэд шаардлагатай санхүү банк, даатгалын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай гэрээтэй ажилладаг эсэх	3.338
Менежментийн орчин үеийн ур чадвар эзэмшсэн байдал	3.409	Ашигт ажиллагааны түвшин (Цэвэр ашиг/Нийт борлуулалт)	3.306
ИДС, МСҮТ бусад сургалтын байгууллагатай хамтарч ажилладаг эсэх	3.182	Бизнесийг хэвийн эрхлэхэд шаардлагатай логистик (тээвэр, агуулах)- ийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай гэрээтэй ажилладаг эсэх	3.234
Үнэлгээний дундаж	3.43	Хөрөнгөө эргэлтэд оруулж орлого олох боломж	3.205
		Түүхий эд нийлүүлэгч болон бусад холбогдох аж үйлдвэрийн кластер бэлэн байгаа эсэх	3.199
		Үнэлгээний дундаж	3.32

Бизнесийн байгууллагууд өөрсдийнхөө үр ашиг, бүтээмжийн үзүүлэлтүүдэд яаралтай авах арга хэмжээ бага ч, анхаарах шаардлагатай гэсэн үнэлгээ өгчээ. Эдгээр үзүүлэлтүүдээс хөдөлмөрийн бүтээмж, нийт бүтээмж зэрэг үзүүлэлтүүд хамгийн өндрөөр үнэлэгдсэн бол түүхий эд нийлүүлэгч болон бусад холбогдох аж үйлдвэрийн кластер бэлэн байгаа эсэх, хөрөнгөө эргэлтэд оруулж орлого олох боломж зэрэг нь хамгийн бага оноотой үнэлэгдсэн байна.

2.3 Монголын бизнесийн орчны сүүлийн 3 жилийн өөрчлөлт

Монголын бизнесийн орчны сүүлийн 3 жилийн өөрчлөлтийг ерөнхий үнэлгээг гаргасан асуулгаар 1-5 хүртлэх оноогоор үнэлүүлж үр дүнг гарган, жигнэсэн дунджийн аргаар тооцооллыг хийв. Тоогоор илэрхийлж буй үнэлгээнд харгалзах утга нь дараах байдалтай болно.

- 1 - Бизнесийн орчин эрс муудсан
- 2- Бизнесийн орчин муудсан
- 3- Бизнесийн орчинд өөрчлөлт гараагүй
- 4- Бизнесийн орчин сайжирсан
- 5- Бизнесийн орчин эрс сайжирсан


Хүснэгт 2.12 Монголын бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээ (голлох үзүүлэлтээр)

Д/Д	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТИЙН КОЭФФИЦИЕНТ (ДЭЭД УТГА 5)	ОРЧНЫ ҮНЭЛГЭЭНИЙ КОЭФФИЦИЕНТ (ДЭЭД УТГА 7)
1	Дэд бүтэц, технологи	2.94	3.43
1.1	Технологи, харилцаа холбоо	2.97	3.43
1.2	Үндсэн дэд бүтэц	2.92	3.43
2	Эдийн засгийн орчин	2.58	2.96
2.1	Хүний нөөцийн хомсдол, ажиллах хүч	2.73	2.94
2.2	Татварын орчин	2.56	2.65
2.3	Санхүүгийн зах зээл	2.44	3.25
3	Засаглал, хууль эрх зүй	2.41	2.69
3.1	Бизнесийн эрхзүйн орчин	2.65	2.53
3.2	Засгийн газрын институцийн тогтолцоо, уялдаа холбоо	2.35	3.12
3.3	Засгийн газрын үйл ажиллагаа	2.28	2.53
4	Нийгэм, соёл	2.53	2.93
4.1	Нийгмийн хандлага	2.92	3.30
4.2	Хүн ам зүй	2.15	2.57
5	Бизнесийн байгууллагын үйл ажиллагаа	2.79	3.37
5.1	Удирдлага, зохион байгуулалт	2.87	3.43
5.2	Байгууллагын үр ашиг, бүтээмж	2.70	3.32
	Нийт орчны дундаж	2.62	3.03

Бизнесийн орчны өөрчлөлтийн дундаж үнэлгээ нь хангалтгүй буюу 2.62 гарсан нь бизнесийн орчин муудсан гэсэн хариулттай дүйж байна. Үүнд хүн амын худалдан авах чадвар, засгийн газрын үйл ажиллагаа, институциудын уялдаа холбоо зэрэг үзүүлэлтүүд нь сүүлийн 3 жилд бусад үзүүлэлтүүдээс илүүтэйгээр муудсан болохыг бизнес эрхлэгчид онцолсон байна.

Бизнесийн орчны өөрчлөлтийн ерөнхий 5 үзүүлэлтийг боломжит дээд утга болох 5 оноотой харьцуулан зураглавал дараах байдалтай байна.


Зураг 2.3 Монголын бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээ (ерөнхий үзүүлэлтүүдээр, коэффициент)



Зураглалаас харвал бизнесийн орчинд сүүлийн 3 жил эерэг өөрчлөлт гараагүй гэж судалгаанд оролцогсдын дийлэнх нь үзсэн төдийгүй нэн ялангуяа засаглал, хууль эрх зүй, эдийн засгийн орчин хамгийн ихээр муудсан гэж дүгнэсэн байна.

Бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээг бүс нутгуудаар, ерөнхий 5 орчны үзүүлэлтүүдээр нь боломжит дээд утга болох 5 оноотой харьцуулан зураглалаар харвал дараах байдалтай байна.

Зураг 2.4 Монголын бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээ (бүс нутгаар)



Зураглалаас харвал бизнесийн орчинд сүүлийн 3 жилд аль ч бүс нутагт эерэг өөрчлөлт гараагүй, ихэнх үзүүлэлтүүд нь муудсан гэж судалгаанд хамрагдагсдын дийлэнх үзсэн. Улаанбаатар хот болон баруун бүсийн аймгуудын бизнесийн орчны өөрчлөлт нь бусад бүс нутгуудтай харьцуулбал нилээн агшилттай харагдаж байна.

Бүс нутгуудыг ерөнхий 5 орчны өөрчлөлтийн үзүүлэлтүүдээр нь байр эзлүүлэн харьцуулан харвал төвийн бүсийн аймгууд дахь бизнесийн орчны өөрчлөлт бусад аймгуудаа бодвол харьцангуй бага, харин баруун бүсийн аймгууд болон Улаанбаатар хотын бизнесийн орчин сүүлийн 3 жилд нилээн муудсан байна.


Хүснэгт 2.13 Монголын бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээ (бүсийн байр эзлүүлсэн байдлаар)

Байр	Дэд бүтэц, технологи	Эдийн засгийн орчин	Засаглал, хууль эрх зүй	Нийгэм, соёл	Бизнесийн байгууллагын үйл ажиллагаа
1	Төвийн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Төвийн бүс	Төвийн бүс
2	Зүүн бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Зүүн бүс
3	Хангайн бүс	Зүүн бүс	Хангайн бүс	Хангайн бүс	Хангайн бүс
4	Улаанбаатар хот	Улаанбаатар хот	Баруун бүс	Улаанбаатар хот	Улаанбаатар хот
5	Баруун бүс	Баруун бүс	Улаанбаатар хот	Баруун бүс	Баруун бүс

Монголын бизнесийн орчны өөрчлөлтийг үнэлгээтэй нь жишиж харьцуулж үзэхэд орчны дундаж үнэлгээний коэффициент нь хангалтгүй буюу 3.03 (боломжит дээд утга 7) гарсан нь яаралтай арга хэмжээ авах зүйл бага ч, анхаарах шаардлагатай гэсэн хариулттай дүйж байгаа хэдий ч муу гэсэн хариулттай тун ойрхон. Харин орчны өөрчлөлтийн дундаж үнэлгээ нь хангалтгүй буюу 2.62 (боломжит дээд утга 5) гарсан нь бизнесийн орчин муудсан болохыг илтгэж байна. Орчны үзүүлэлтүүдээс татварын орчин, санхүүгийн зах зээл, засгийн газрын институцийн тогтолцоо, уялдаа холбоо, засгийн газрын үйл ажиллагааны үзүүлэлтүүд муу үнэлгээтэй төдийгүй сүүлийн 3 жилд улам муудсан гэж үнэлэгдсэн. Мөн хүн ам зүйн үзүүлэлт нь аль ч үнэлгээгээрээ бусад үзүүлэлтээс муу гарсан. Энэ нь сүүлийн 3 жилийн хугацаанд хүн амын худалдан авах чадвар буурч буй нь бизнесийн орчинд сөргөөр нөлөө үзүүлж байгааг илтгэнэ.

Монголын бизнесийн орчны өөрчлөлт болон үнэлгээний харьцуулалтыг үнэлгээний эрэмбээр жагсаавал дараах байдалтайгаар дүрслэгдэнэ.

Зураг 2.5 Монголын бизнесийн орчны өөрчлөлт болон үнэлгээ



Зураглалаас аль аль талаараа бусдаасаа арай дээгүүр гэж үнэлэгдсэн, мөн бусдаасаа хамгийн муу байдлаар үнэлэгдсэн 3 үзүүлэлтийг тодотговол:

Бусад үзүүлэлтээс дээгүүр үнэлэгдсэн 3 үзүүлэлт:

- Технологи, харилцаа холбоо
- Үндсэн дэд бүтэц
- Бизнесийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт

Бусад үзүүлэлтээс хамгийн доогуур үнэлэгдсэн 3 үзүүлэлт:

- Засгийн газрын институцийн тогтолцоо, уялдаа холбоо
- Засгийн газрын үйл ажиллагаа
- Хүн ам зүйн хүчин зүйл

Эндээс дүгнэхэд хүн амын бодит худалдан авах чадвар, түүний бууралт нь Монголын бизнесийн орчинд хамгийн сөргөөр нөлөөлж буй хүчин зүйл бөгөөд түүний дараах хүчин зүйлс нь засаглал, хууль эрх зүйн хүчин зүйлс, тодруулбал засгийн газрын үйл ажиллагаанаас ихээхэн хамааралтай санхүүгийн зах зээл, татварын орчин, бизнесийн эрх зүйн орчин зэрэг үзүүлэлтүүд нь туйлын хангалтгүй хэмээн үнэлэгдсэн байна. Эдгээрээс хамаарч бизнесийн орчин бүхэлдээ муу үнэлгээг авсан. Өөрөөр хэлбэл эдийн засагт тохиолдож буй аливаа хямралын шалтгаан нь засаглал, хууль эрх зүйн хүчин зүйлээс шууд хамааралтай байна.

ГУРАВДУГААР ХЭСЭГ. БИЗНЕСИЙН ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ


3.1 Монгол улсад бизнес эрхлэхэд гардаг нийтлэг хүндрэл

3.1.1 Шинэ бизнес эхлүүлэхэд гардаг нийтлэг хүндрэл

Дэлхий даяар гарааны бизнес буюу шинэ бизнес эрхлэлтийг дэмжиж түүнийг төлөвшиж, хөгжихөд таатай экосистемийг бүрдүүлэхэд улс орнууд ихээхэн анхаарч засгийн газрын түвшинд бодлого боловсруулан ажиллаж байна. Монгол улсад шинэ бизнес эрхлэлтийг дэмжих, түүнийг хөгжүүлэх таатай орчин, экосистемийг бий болгох нь өнөөгийн бизнесийн салбарын тулгамдсан асуудлын нэг болжээ.

Шинэ бизнес эрхлэхэд тулгарч буй нийтлэг хүндрэлийг аж ахуйн нэгжийн нэр авах, бүртгүүлэх, шинээр бизнес эхлэхэд зарцуулах хугацаа, шинээр бизнес эхлэхэд гарах зардал, шинээр бизнес эхлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр зэрэг үзүүлэлтээр авч үзэхэд судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 1). 64% нь шаардлагатай зардал олоход, 2). 62% нь шинэ бизнес эхлүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр, 3). 49% нь шинэ бизнес эхлэхэд зарцуулах хугацааг тус тус маш их хүндрэл учруулдаг хэмээн хариулжээ.

Зураг 3.1 Шинэ бизнес эхлүүлэхэд тулгарч буй хүндрэл (хувиар)



Шинэ бизнес эрхлэхэд тулгарч буй асуудлыг бүс нутгийн хүрээнд авч үзэхэд тулгарч буй бэрхшээлтэй асуудлын эрэмбүүд харьцангуй ойролцоо байна. Харин улсын дундажтай харьцуулахад Хангайн, Улаанбаатар, Баруун бүсүүдэд илүү хүндрэлтэй байгаа болно.


Хүснэгт 3.1 Шинэ бизнес эхлүүлэхэд тулгарч буй хүндрэл (бүс нутгаар, хувиар)

Хүндрэл	Шинээр бизнес эхлэхэд гарах зардал	Шинээр бизнес эхлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр	Шинээр бизнес эхлэхэд зарцуулах хугацаа	Аж ахуйн нэгжийн нэр авах	Бүртгүүлэх
Хангайн бүс	71.4	69.2	51.9	28.7	25.5
Улаанбаатар	70.7	64.6	53.3	43.7	35.9
Баруун бүс	68.9	68.4	54.6	42.7	39.7
Улсын дундаж	63.7	61.8	49.5	32.6	28.2
Төвийн бүс	50.6	51.1	41	18.4	15.7
Зүүн бүс	46.3	47.9	42.7	22.9	19.2

Тайлбар: Шинэ бизнес эхлэхэд улаан өнгө- хамгийн их, ногоон– хамгийн бага хүндрэл учруулдаг.

Шинээр бизнес эрхлэхэд тулгарч буй хамгийн хүндрэлтэй гурван асуудлыг үйл ажиллагааны чиглэлээр нь ангилан Зураг 3.2-т харуулав. Шинэ бизнес эрхлэхэд гарах зардал, хөрөнгийн эх үүсвэр Аялал жуулчлалын салбарт хамгийн их тулгамдаж байгаа бол шинэ бизнес эрхлэхэд зарцуулах цаг хугацаа мал аж ахуйн салбарт хүндрэлтэй байна.

Зураг 3.2 Шинэ бизнес эхлэхэд тулгарч буй хүндрэл (үйл ажиллагааны чиглэлээр, хувиар)



Шинэ бизнес эхлэхэд тулгарч буй нийтлэг хүндрэлүүд дотроос хамгийн их бэрхшээлийг учруулж байгаа шинэ бизнес эхлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр болон гарах зардлыг бууруулахын тулд бизнес төсөлд нь үнэлгээ хийсний үндсэн дээр барьцаа хөрөнгө шаардахгүйгээр, аль болох бага хүүтэй зээлийг олгох нь чухал байна.

3.1.2 Техникийн нөхцөл (зөвшөөрөл) авахад гардаг хүндрэл

Техникийн нөхцөл буюу тусгай зөвшөөрөл авахад гарч буй хүндрэлийн талаар тодруулахад судалгаанд хамрагдсан аж ахуй эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авахад хүндрэл учруулдаг асуудалд:

1. Төрийн байгууллагын хүнд суртал-67%
2. Тусгай зөвшөөрөл авахад зарцуулах хугацаа-65.3%
3. Бүрдүүлэх бичиг баримтын тоо-64.1% зэрэг нь хамгийн их хүндрэл учруулдаг гэж үзжээ.

Харин судалгаанд оролцогчдын 6.5-14.2% нь хүндрэл бараг байдаггүй гэж үзсэн байна.

Хүснэгт 3.3 Техникийн нөхцөл авахад тулгарч буй хүндрэл (хувиар)

Үзүүлэлт	Хүндрэл					Нийт
	Маш их	Их	Дунд зэрэг	Бага	Үгүй	
Төрийн байгууллагын хүнд суртал	31.2	35.8	26.5	4.4	2.1	100.0
Бүрдүүлэх бичиг баримтын тоо	23.2	40.9	29.0	5.3	1.5	100.0
Холбогдох албан тушаалтны гарын үсгийн тоо	21.7	38.4	31.3	6.8	1.8	100.0
Зарцуулах цаг хугацаа	22.9	42.4	27.9	5.3	1.5	100.0
Авилгал, хээл хахуул	25.0	31.4	29.4	9.1	5.1	100.0
Хууль, дүрэм, стандарт нь бодит байдал дах нийцэл	22.1	29.3	36.1	9.0	3.5	100.0

Тайлбар: Улаан өнгө- хамгийн их хүндрэл учруулдаг.

Бүс нутгийн хэмжээнд хүндрэлүүдийг авч үзвэл Улаанбаатар болон Баруун бүсэд хамгийн их хүндрэлтэй, харин Төвийн болон Зүүн бүсэд харьцангуй хүндрэл бага учирдаг байна.

Хүснэгт 3.4 Техникийн зөвшөөрөл авахад гарч буй хүндрэл (бүс нутгаар, хувиар)

Үзүүлэлт	Төрийн байгууллагын хүнд суртал	Бүрдүүлэх бичиг баримтын тоо	Зарцуулах цаг хугацаа	Холбогдох албан тушаалтны гарын үсгийн тоо	Авилгал, хээл хахуул	Хууль, дүрэм, стандарт нь бодит байдал дах нийцэл
Улаанбаатар	75.6	67.4	74.4	68.5	65.1	59.7
Баруун бүс	73.6	68	67.9	63.3	67.1	57
Улсын дундаж	67	64.1	65.3	60.1	56.4	51.4
Хангайн бүс	65.3	69.1	66	61.1	54.6	48.2
Төвийн бүс	58.8	54.5	52.3	50	40.4	41.3
Зүүн бүс	54.4	57	61.4	51.3	49	45.7


Тайлбар: Техникийн зөвшөөрөл авахад: Улаан өнгө- хамгийн их, ногоон – хамгийн бага хүндрэл учруулдаг.

Техникийн нөхцөл буюу тусгай зөвшөөрөл авахад гарч буй хүндрэлийг багасгахын тулд зөвшөөрөл олгодог газруудын үйл ажиллагааг уялдуулж, шат дамжлагыг багасгах, зөвшөөрөл олгож буй хэлбэрийг цахимжуулах, төрийн байгууллагын хүнд суртлыг арилгахын тулд төрийн оролцоог аль болох багасгах шаардлагатай байна.

Техникийн нөхцөл (зөвшөөрөл) авахад гардаг зардал

Судалгаанд оролцогчдын өгсөн хариултаас үзэхэд тусгай зөвшөөрөл авахад 7.6% нь зардал бараг гардаггүй, 38.2% нь дундаж зардал, 51.2% нь их зардал гардаг гэж үзсэн байна.

Зураг 3.3 Техникийн нөхцөл авахад гарч буй зардал (хувиар)



Үзүүлэлт тус бүрээр гарч буй зардлыг тодруулахад хүснэгт 3.5-д үзүүлснээр авилга, хээл хахуульд, бичиг баримт бүрдүүлэхэд (55.6%-58%) хамгийн их зардал гаргадаг байна.

Хүснэгт 3.5 Техникийн зөвшөөрөл авахад гарч буй зардал (хувиар)

Үзүүлэлт	Зардал					
	Маш өндөр	Өндөр	Дундаж	Бага	Байхгүй	Нийт
Төрийн байгууллагын хүнд суртал	20.7	34.1	38.8	3.9	2.6	100
Бүрдүүлэх бичиг баримтын тоо	18.7	36.9	37.8	5.1	1.5	100
Холбогдох албан тушаалтны гарын үсгийн тоо	18.3	32.6	38.9	6.4	3.8	100
Зарцуулах цаг хугацаа	22.3	33.0	38.3	4.6	1.8	100
Авилгал, хээл хахуул	24.1	33.9	33.4	4.4	4.1	100
Хууль, дүрэм, стандарт нь бодит байдал дах нийцэл	19.9	30.0	40.5	5.8	3.7	100

Тайлбар: Техникийн зөвшөөрөл авахад: Улаан өнгө- хамгийн их хүндрэл учруулдаг.

Техникийн зөвшөөрөл авахад гарч буй зардлыг бүсээр авч үзэхэд Төвийн болон Зүүн бүсэд бусад бүс болон улсын дундажтай харьцуулахад харьцангуй бага зардал харин Улаанбаатар хот болон Баруун бүсэд хамгийн их зардал гардаг байна.

Хүснэгт 3.6 Техникийн зөвшөөрөл авахад гарч буй зардал (бүс нутгаар, хувиар)

Үзүүлэлт	Авилгал, хээл хахуул	Бүрдүүлэх бичиг баримтын тоо	Төрийн байгууллагын хүнд суртал	Зарцуулах цаг хугацаа	Холбогдох албан тушаалтны гарын үсгийн тоо	Хууль, дүрэм, стандарт нь бодит байдал дах нийцэл
Улаанбаатар	63.4	60.5	59.2	61.9	55.6	54.1
Баруун бүс	63.4	64.5	68.2	59.6	55.3	55.7
Хангайн бүс	60.4	58	53.4	56.9	50.5	50.3
Улсын дундаж	58	55.7	54.8	55.3	50.9	49.9
Төвийн бүс	45.7	46.1	46.1	46.8	44.8	38.4
Зүүн бүс	47.1	36.7	34	39.6	39.6	45

Тайлбар: Техникийн зөвшөөрөл авахад: Улаан өнгө- хамгийн их, ногоон – хамгийн бага хүндрэл учруулдаг.


Судалгааны үр дүнгээс харахад техникийн нөхцөл авахад авилгал, хээл хахуульд хамгийн их зардал гардаг ажээ. Бүс нутгийн хувьд Хангайн, Зүүн, Улаанбаатар хотын хувьд техникийн нөхцөл авахад хамгийн их зардал гарч байгаа үзүүлэлт нь улсын дундажтай ижил байгаа бол Баруун бүсэд төрийн байгууллагын хүнд суртал, Төвийн бүсэд зарцуулж буй цаг хугацаанд хамгийн их зардал гаргасан байна.

3.1.3 Хөрөнгө бүртгүүлэхтэй холбоотой асуудал

Судалгаанд оролцогчдын 11.6-16.6% нь хөрөнгө бүртгүүлэхэд ямар нэг саад, тотгор учирдаггүй гэж хариулжээ. Харин бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүд хөрөнгө бүртгүүлэхэд дараах асуудлууд хамгийн их саад, тотгор болдог хэмээжээ. Үүнд:

1. Үл хөдлөх хөрөнгө бүртгүүлэх үйл явц-41.6%
2. Эргэлтийн хөрөнгө бүртгүүлэх үйл явц-40%
3. Хөрөнгийн бүртгэлийн хураамжийн хэмжээ-38.3%


Зураг 3.4 Хөрөнгө бүртгүүлэхэд тулгарч буй хүндрэл (хувиар)




Бүс нутгаар хөрөнгө бүртгүүлэхэд тулгарч буй асуудлыг авч үзэхэд үзүүлэлт тус бүр дээр Баруун бүсэд хамгийн их хүндрэл тулгарч байгаа нь судалгааны үр дүнгээс харагдлаа. Үүний дараа Улаанбаатар болон Хангайн бүс орж байгаа бол Төв болон Зүүн бүсэд бусад бүстэй харьцуулахад хөрөнгө бүртгүүлэхэд тулгарч буй асуудал харьцангуй бага байна.

Тодруулбал хөрөнгө бүртгүүлэхэд бүртгэлийн хураамжийн хэмжээ их хэмээн нийт судалгаанд оролцогчдын 38% нь үзсэн бол Баруун бүсэд 46.4%, Улаанбаатар хотод 43.6%, Хангайн бүсэд 37.5%, Зүүн бүсэд 31.4%, Төвийн бүсэд 28.4% нь тус тус хариулжээ.


Зураг 3.5 Хөрөнгийн бүртгэлийн хураамжийн хэмжээ их (бүс нутгаар, хувиар)




Зураг 3.6 Хөрөнгө бүртгүүлэхэд зарцуулах хугацаа их (бүс нутгаар, хувиар)




Зураг 3.7 Үл хөдлөх хөрөнгө бүртгүүлэх үйл явц төвөгтэй (бүс нутгаар, хувиар)



Зураг 3.8 Хөрөнгө бүртгүүлэх үйл явцын цахимжуулалт муу (бүс нутгаар, хувиар)



Зураг 3.9 Эргэлтийн хөрөнгө бүртгүүлэх үйл явц төвөгтэй (бүс нутгаар, хувиар)




Аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа явуулж буй чиглэл тус бүрээр хөрөнгө бүртгүүлэхэд тулгамдаж буй асуудал өөр өөр байгааг хүснэгт 3.7-оос харж болно. Худалдааны салбарт эргэлтийн болон үл хөдлөх хөрөнгө бүртгүүлэх, үйлчилгээ болон боловсруулах үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд үл хөдлөх хөрөнгө бүртгүүлэх болон зарцуулж буй цаг хугацаанд, уул уурхай, газар тариалан, барилгын салбарын хувьд хөрөнгө бүртгүүлэх цахим систем, бүртгэлийн хураамж зэрэг нь их хүндрэл учруулдаг байна.

Хүснэгт 3.7 Хөрөнгө бүртгүүлэхтэй холбоотой гарч буй хүндрэл (ААН-ийн үйл ажиллагааны чиглэлээр, хувиар)

Салбар	Хөрөнгийн бүртгэлийн хураамжийн хэмжээ их	Үл хөдлөх хөрөнгө бүртгүүлэх үйл явц төвөгтэй	Эргэлтийн хөрөнгө бүртгүүлэх үйл явц төвөгтэй	Хөрөнгө бүртгүүлэх үйл явцын цахимжуулалт муу	Хөрөнгө бүртгүүлэхэд зарцуулах хугацаа их
Худалдаа	42.8	44.2	43.5	39.9	39.7
Үйлчилгээ	33.2	44.5	39.1	37.3	41.9
Боловсруулах үйлдвэрлэл	37.2	39.0	38.6	35.7	38.8
Уул уурхай	27.3	22.7	27.3	40.9	27.3
Барилга	38.2	35.2	32.1	29.6	40.0
Тээвэр	29.4	52.9	41.2	52.9	52.9
Мал аж ахуй	21.6	37.8	37.8	38.9	37.8
Газар тариалан	26.3	23.7	25.0	24.3	40.5
Мэдээллийн технологи, харилцаа холбоо	26.1	26.1	27.3	34.8	35.0
Аялал жуулчлал	41.2	58.8	52.9	37.5	37.5

Тайлбар: Улаан өнгө- хамгийн их, ногоон – хамгийн бага хүндрэл учруулдаг.

Зураг 3.10 Хөрөнгө бүртгүүлэхэд тулгарч буй хүндрэл (ААН-ийн хэмжээгээр, хувиар)



Зураг 3.10-аас харахад хөрөнгө бүртгүүлэхэд жижиг, дунд компаниудын (39%-41%), харин том компаниудын хувьд 32% нь хүндрэл учирдаг гэжээ.

Хөрөнгө бүртгүүлэхтэй холбоотой асуудлаар бизнес эрхлэгчдэд учирч буй хамгийн их хүндрэлтэй асуудлуудад хөрөнгийн бүртгэлийн хураамжийн хэмжээ, үл хөдлөх хөрөнгө бүртгүүлэх үйл явц, эргэлтийн хөрөнгө бүртгүүлэх үйл явц зэрэг байгаа ба хөрөнгө бүртгүүлэх хураамжийн хэмжээ Баруун бүс болон Улаанбаатар хотод улсын дунджаас өндөр, харин Баруун бүсэд хөрөнгө бүртгүүлэхтэй холбоотой асуудал үзүүлэлт бүрээр хүндрэлтэй байна.

3.1.4 Санхүүжилттэй холбоотой асуудлууд

Бизнес эрхлэхэд санхүүжилттэй холбоотой тулгарч буй асуудлын талаар авч үзэхэд /Хүснэгт 3.8/ судалгаанд оролцогчдын 11.1%-25.6% нь ямар нэг асуудал тулгардаггүй гэж хариулжээ. Харин судалгаанд оролцогчдын 74.4-88.9% нь санхүүжилттэй холбоотой хамгийн их тулгарч буй асуудалд:

1. Батлан даалтаар санхүүжилт авах боломж муу-54%
2. Санхүүжилтийн орчин үеийн хэлбэрүүд (angel investor, venture) муу хөгжсөн-47.9% гэж хариулжээ.

Өөрөөр хэлбэл бизнес эрхлэгчдийн хувьд санхүүгийн эх үүсвэр дутагдалтай байгаа бөгөөд ихэнх нь дотоодын банкуудаас зээлийн санхүүжилт авдаг байна.

Бизнес эрхлэгчдэд тулгарч буй санхүүжилттэй холбоотой хүндрэлтэй асуудлыг даван туулахын тулд хөрөнгийн зах зээлд гарах, гадны шууд хөрөнгө оруулалтыг татах, түрээсийн санхүүжилтийг өргөжүүлэхэд төрийн бодлогыг чиглүүлэх, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, бизнесийн санхүүжилтын орчин үеийн хэлбэрүүдийг бий болгож, хөгжүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 3.8 Санхүүжилттэй холбоотой тулгарч буй хүндрэл (хувиар)


Үзүүлэлт	Огт санал нийлэхгүй байна	Санал нийлэхгүй байна	Зарим тохиолдолд санал нийлнэ	Санал нийлж байна	Бүрэн санал нийлж байна	Нийт
Зээлдүүлэгч тал зээлийн гэрээг чандлан баримталдаг	11.4	21.1	42.0	19.6	6.0	100
Зээл авагчийн эрхийн хуулиар олгогдсон хамгаалалт сайн	14.6	26.4	43.0	13.9	2.1	100
Зээлийн мэдээллийн сан (зээлийн эх үүсвэрүүд, хэмжээ, зээл авах боломж г.м мэдээлэл) хангалттай	15.0	25.4	42.3	14.7	2.6	100

Санхүүжилтийн орчин үеийн хэлбэрүүд (angel investor, venture) сайн хөгжсөн	17.6	30.3	40.9	9.5	1.7	100
Батлан даалтаар санхүүжилт авах боломж сайн	23.5	30.5	34.9	9.9	1.2	100


Тайлбар: Улаан өнгө- хамгийн их, ногоон – хамгийн бага хүндрэл учруулдаг.

Бүс нутгаар санхүүжилттэй холбоотой асуудлыг авч үзэхэд Баруун бүсийг бусад бүстэй харьцуулахад үзүүлэлт тус бүрээр хамгийн их хүндрэл тулгарч байна. Үүний дараа Улаанбаатар хот болон Хангайн бүс орж байгаа бол Төв болон Зүүн бүсэд бусад бүстэй харьцуулахад санхүүжилттэй холбоотой тулгарч буй асуудал харьцангуй бага байна.


Зураг 3.11. Батлан даалтаар санхүүжилт авах боломж муу (бүс нутгаар, хувиар)




Зураг 3.12. Зээл авагчийн эрхийн хуулиар олгогдсон хамгаалалт муу (хувиар)




Зураг 3.13. Санхүүжилтын орчин үеийн хэлбэрүүд хөгжөөгүй, бүсээр (хувиар)



Зураг 3.14. Зээлийн мэдээллийн сан хангалтгүй, бүсээр (хувиар)



Зураг 3.15. Зээлдүүлэгч тал зээлийн гэрээг чандлан баримталдаггүй (бүсээр, хувиар)



Санхүүжилттэй холбоотой тулгарч буй асуудлуудыг ААН-ийн үйл ажиллагаа явуулж буй чиглэлээр нь харахад /Хүснэгт 3.9/ үйл ажиллагааны чиглэлээс хамаарахгүйгээр ижил буюу батлан даалтаар санхүүжилт авах боломж муу, санхүүжилтын орчин үеийн хэлбэр муу хөгжсөн гэж үзжээ.

Уул уурхай, барилгын салбарынхны хувьд зээл авагчийн хуулиар олгогдсон эрхийн хамгаалалт сул, тээврийн салбарын хувьд зээлийн мэдээллийн сан хангалтгүй байгаа зэрэг нь хамгийн их хүндрэл учруулдаг байна.


Хүснэгт 3.9 Санхүүжилттэй холбоотой тулгарч буй асуудал (ААН-ийн үйл ажиллагааны чиглэлээр, хувиар)

Салбар	Зээлдүүлэгч тал зээлийн гэрээг чандлан баримталдаггүй	Зээл авагчийн эрхийн хуулиар олгогдсон хамгаалалт муу	Зээлийн мэдээллийн сан хангалтгүй	Санхүүжилтийн орчин үеийн хэлбэрүүд хөгжөөгүй	Батлан даалтаар санхүүжилт авах боломж муу
Худалдаа	33.3	42.9	39.8	48.2	55.2
Үйлчилгээ	33.1	35.9	40.2	49.2	57.9
Боловсруулах үйлдвэрлэл	29.4	37.1	35.7	48.2	50.0
Уул уурхай	22.7	45.5	40.9	45.0	47.6

Барилга	37.7	53.8	44.4	49.1	49.0
Тээвэр	23.5	47.1	64.7	47.1	56.3
Мал аж ахуй	36.1	38.9	38.9	50.0	58.3
Газар тариалан	17.9	40.0	39.0	43.2	52.5
Мэдээллийн технологи, харилцаа холбоо	22.7	42.9	30.0	45.0	47.6
Аялал жуулчлал	31.3	52.9	41.2	57.9	68.4

Тайлбар: Улаан өнгө- хамгийн их, ногоон – хамгийн бага хүндрэл учруулдаг.

Зураг 3.16 Санхүүжилт авахад тулгарч буй хүндрэл (ААН-ийн хэмжээгээр, хувиар)



Зураг 3.16-д үзүүлснээр жижиг, дунд ААН-н 52%-54% нь санхүүжилттэй холбоотой нийтлэг хүндрэл учирдаг гэж үзсэн бол том ААН-н хувьд харьцангуй бага буюу 34% нь хүндрэл учирдаг гэжээ.

3.1.5 Хувьцаа эзэмшигч/ хөрөнгө оруулагчтай холбоотой асуудал

Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчтай холбоотойгоор тулгарч буй асуудлуудыг авч үзэхэд судалгаанд оролцогчдын 40-45% нь хүндрэл учирдаг хэмээн хариулжээ. Хамгийн их тулгарч буй хүндрэлд дараах асуудлууд багтсан. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигч/хөрөнгө оруулагчийг мэдээллээр хангадаг байдал муу-45.1%
2. Хувьцаа эзэмшигч/хөрөнгө оруулагчийн эрхийн хуулиар олгогдсон хамгаалалт муу-42.8%


Хүснэгт 3.10 Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчтай холбоотой гарч буй хүндрэл (хувиар)

Үзүүлэлт	Огт санал нийлэхгүй байна	Санал нийлэхгүй байна	Зарим тохиолдолд санал нийлнэ	Санал нийлж байна	Бүрэн санал нийлж байна	Нийт
Хувьцаа эзэмшигчид/ хөрөнгө оруулагчийн эрхийн хуулиар олгогдсон хамгаалалт сайн	14.0	28.8	46.0	9.7	1.4	100
Хувьцаа эзэмшигчид /хөрөнгө оруулагчийг мэдээллээр хангадаг байдал сайн	15.2	29.9	44.5	9.0	1.5	100
Хөрөнгө оруулагчдын компанийн удирдлага дах үүрэг, оролцоо сайн	14.0	28.0	45.6	11.1	1.4	100
Компанийн засаглал сайн	12.1	28.5	46.5	10.9	1.9	100


Тайлбар: Улаан өнгө- хамгийн их, ногоон – хамгийн бага хүндрэл учруулдаг.

Хувьцаа эзэмшигч/хөрөнгө оруулагчтай холбоотойгоор тулгарч буй асуудлыг бүс нутгаар авч үзэхэд /Зураг 3.17-3.20/ үзүүлэлт тус бүрээр бусад бүстэй харьцуулахад Баруун бүсэд хамгийн их хүндрэл тулгардаг байна. Улсын дундажтай харьцуулахад үзүүлэлт тус бүрээр Баруун болон Улаанбаатар хотод өндөр байгаа бол Төвийн болон Зүүн бүсийн хувьд бага байна. Хангай бүсийн хувьд хувьцаа эзэмшигч/хөрөнгө оруулагчийн эрхийн хуулиар олгогдсон хамгаалалт муу гэсэн үзүүлэлтээс бусад үзүүлэлтийн хувьд улсын дунджаас доогуур гарчээ.


Зураг 3.17. Хувьцаа эзэмшигч/хөрөнгө оруулагчийн эрхийн хуулиар олгогдсон хамгаалалт муу (бүсээр, хувиар)




Зураг 3.19. Хувьцаа эзэмшигч/хөрөнгө оруулагчийг мэдээллээр хангадаг байдал муу (бүсээр, хувиар)



Зураг 3.18. Хөрөнгө оруулагчдын компанийн удирдлага дах үүрэг, оролцоо муу (бүсээр, хувиар)



Зураг 3.20. Компанийн засаглал муу (бүсээр, хувиар)



3.1.6 Татвартай холбоотой асуудал

Татвартай холбоотой асуудлаар бизнес эрхлэгчдийн саналыг авч үзэхэд судалгаанд хамрагдагсдын 25.6%-12.5% нь татвартай холбоотой ямар нэг асуудал байхгүй гэж үзсэн бол 74.4%-87.5% нь хамгийн их тулгамдаж буй асуудалд дараах хариултыг өгчээ. Үүнд:

1. Татварын хувь хэмжээ боломжийн бус/их-61.5%
2. Татварын орчин тааламжгүй-57.5% гэсэн үзүүлэлтүүд багтжээ.


Хүснэгт 3.11 Татвартай холбоотой тулгарч буй асуудал (хувиар)

Үзүүлэлт	Огт санал нийлэхгүй байна	Санал нийлэхгүй байна	Зарим тохиолдолд санал нийлнэ	Санал нийлж байна	Бүрэн санал нийлж байна	Нийт
Татварын орчин тааламжтай	20.0	37.5	30.0	12.5	0.0	100
Татварын хувь хэмжээ боломжийн	25.6	35.9	23.1	15.4	0.0	100
Татварын тайлан бэлтгэх, тайлагнахад төвөггүй	10.3	28.2	35.9	25.6	0.0	100
Татварын байгууллагын үйл ажиллагаа шуурхай, хүндрэлгүй	12.8	28.2	38.5	17.9	2.6	100


Тайлбар: Улаан өнгө- хамгийн их, ногоон – хамгийн бага хүндрэл учруулдаг.

Татвартай холбоотой тулгарч буй асуудлуудыг бүс нутгаар Зураг 3.21-3.24-д үзүүлээ. Татварын орчин тааламжгүй гэж нийт судалгаанд оролцогчдын 57%, Баруун бүсэд 63.8%, Улаанбаатар хотод 61.3% нь үзжээ. Улсын дундажтай харьцуулахад Зүүн, Баруун, Улаанбаатар хотод татварын хувь хэмжээ өндөр гэж хариулсан хариулагсад их байгаа бол Төвийн болон Хангайн бүсэд улсын дунджаас доогуур байна.


Зураг 3.21. Татварын орчин тааламжгүй (бүсээр, хувиар)




Зураг 3.22. Татварын тайлан бэлтгэх, тайлагнахад төвөгтэй (бүсээр, хувиар)




Зураг 3.23. Татварын хувь хэмжээ боломжийн бус (бүсээр, хувиар)



Зураг 3.24. Татварын байгууллагын үйл ажиллагаа шуурхай, хүндрэлтэй (бүсээр, хувиар)



Зураг 3.25 Татвартай холбоотой хүндрэл (ААН-ийн хэмжээгээр, хувиар)



Судалгаанд оролцогчдын хувьд ААН-ийн хэмжээнээс хамаарахгүйгээр татвартай холбоотой нийтлэг хүндрэл болох татварын орчин бүрдээгүй, татварын хувь хэмжээ их байгаа нь хүндрэл их үзүүлдэг гэж хариулжээ. Төрөөс татварын эрүүл таатай орчныг бүрдүүлэхэд анхаарч, татварын хувь хэмжээний шатлалыг дахин нягталж үзэх, шинээр бизнесүүдийг эхний жилүүдэд татвараас чөлөөлөх бодлогыг хэрэгжүүлэх нь чухал байна.

3.1.7 Бизнесийн маргаантай холбоотой асуудал

Бизнесийн үйл ажиллагааны явцад бизнестэй холбоотой маргаан их гардаг гэж судалгаанд оролцогчдын 43.8%, маргааныг шүүх шударга, шуурхай шийдвэрлэдэггүй гэж 48.5%, шүүхийн шийдвэрийг биелүүлэх байгууллагын үйл ажиллагаа муу хэмээн 47.9% тус тус үзжээ. / Хүснэгт 3.12/

Бизнесийн маргаантай холбоотой үзүүлэлтүүдийг бүс нутгаар нь харвал үзүүлэлт тус бүрээр бусад бүстэй харьцуулахад Улаанбаатар болон Баруун бүсийн хувьд хамгийн их маргаантай асуудал гардаг байна.

Хүснэгт 3.12 Бизнесийн маргаантай холбоотой тулгарч буй асуудал (бүс нутгаар, хувиар)

Бүс нутаг	Бизнесийн маргаан их гардаг	Бизнесийн маргаантай асуудлыг шүүх шударга шийдвэрлэдэггүй	Бизнесийн маргаантай асуудлыг шүүх шуурхай шийдвэрлэдэггүй	Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын үйл ажиллагаа муу
Улаанбаатар	55	53.9	62.4	60.8
Баруун бүс	49.8	52.8	55.3	50
Улсын дүн	43.8	45.6	48.5	47.9
Хангайн бүс	40.8	47.1	46.1	48.4
Зүүн бүс	37.7	38.9	28.9	36.1
Төвийн бүс	29.5	29.7	34.7	33.3

Тайлбар: Улаан өнгө- хамгийн их, ногоон – хамгийн бага хүндрэл учруулдаг.

3.1.8 Дампууралтай холбоотой асуудал

ААН-н дампууралтай холбоотой асуудлыг үндсэн 3 үзүүлэлтээр авч үзсэн бөгөөд улсын дунджаар судалгаанд оролцогчдын 45.2% нь дампуурлаа зарлахад хуулийн байгууллага муу ажилладаг бөгөөд аль аль талууд хохирол ихтэй үлддэг, 45.1% нь дампуурлаа зарлахад бэрхшээлтэй, төвөг чирэгдэл ихтэй, 44.7% нь дампууралтай холбоотой хуулийн зохицуулалт муу гэж үзсэн.

Бүс нутгийн хэмжээнд эдгээр 3 асуудлыг авч үзэхэд бусад бүстэй харьцуулахад үзүүлэлт тус бүрээр Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 52-55.5%-тай байв.

Хүснэгт 3.13 Бизнесийн маргаантай холбоотой тулгарч буй асуудал (бүс нутгаар, хувиар)

Бүс нутаг	Дампууралтай холбоотой хуулийн зохицуулалт муу	Дампуурлаа зарлахад бэрхшээлтэй, төвөг чирэгдэл ихтэй	Дампуурлаа зарлахад хуулийн байгууллага муу, ажилладаг бөгөөд аль аль талууд хохирол ихтэй үлддэг.
Улаанбаатар	52.9	52.0	55.5
Баруун бүс	49.1	46.0	46.0
Хангайн бүс	45.4	45.6	47.7
Улсын дүн	44.7	45.1	45.2
Зүүн бүс	42.3	42.2	30.7
Төвийн бүс	28.9	35.3	33.3

Тайлбар: Улаан өнгө- хамгийн их, ногоон – хамгийн бага хүндрэл учруулдаг.


Хүснэгтэд дампууралтай холбоотой дээрх 3 үзүүлэлтийг ААН-н үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзлээ. Барилга, мэдээллийн технологи, харилцаа холбоо, газар тариалангийн салбараас судалгаанд хамрагдагсдын хувьд бусад салбаруудтай харьцуулахад дампууралтай холбоотой 3 үзүүлэлтийн хувьд хүндрэл харьцангуй их тулгардаг байна.

Хүснэгт 3.14 Бизнесийн маргаантай холбоотой тулгарч буй асуудал (ААН-н үйл ажиллагааны чиглэлээр, хувиар)

Салбар	Дампууралтай холбоотой хуулийн зохицуулалт муу	Дампуурлаа зарлахад бэрхшээлтэй, төвөг чирэгдэл ихтэй	Дампуурлаа зарлахад хуулийн байгууллага муу ажилладаг бөгөөд аль аль талууд хохирол ихтэй үлддэг.
Худалдаа	47.0	46.0	46.2
Үйлчилгээ	44.4	46.5	46.2
Боловсруулах үйлдвэрлэл	42.7	40.5	47.9
Уул уурхай	50.0	50.0	52.6
Барилга	38.8	38.8	32.7
Тээвэр	50.0	50.0	50.0
Мал аж ахуй	37.5	50.0	35.5
Газар тариалан	36.7	30.0	30.0
Мэдээллийн технологи, харилцаа холбоо	26.3	36.8	31.6
Аялал жуулчлал	64.7	56.3	52.9

Тайлбар: Улаан өнгө- хамгийн их, ногоон – хамгийн бага хүндрэл учруулдаг.

Зураг 3.26. Дампууралтай холбоотой тулгарч буй асуудал (ААН-н хэмжээгээр, хувиар)




Том аж ахуйн нэгжүүдийн 39%, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн 45%-46% дампууралтай холбоотой хүндрэл тулгардаг гэж харьцангуй ойролцоо үнэлсэн байна. Харин дампууралтай холбоотой хүндрэл бараг гардаггүй гэж 8%-10% нь хариулжээ.

Бизнесийн гэрээ зөрчигдсөн тохиолдолд

Бизнесийн гэрээ зөрчигдсөн үед 36.7% нь харилцан тохиролцдог бол, 34.4% нь шүүхэд ханддаг, 28.9% нь хуулийн байгууллагад хандалгүйгээр хохироод үлддэг гэжээ.

Зураг 3.27. Бизнесийн гэрээ зөрчигдсөн үед авдаг арга хэмжээ (хувиар)



3.2 ГАДААД ХУДАЛДАА ЭРХЛЭХЭД ГАРДАГ НИЙТЛЭГ ХҮНДРЭЛИЙГ ҮНЭЛЭХ

Гадаад худалдаа эрхлэхэд гардаг нийтлэг хүндрэлүүдийг дараах үндсэн чиглэлээр тодорхойлсон болно. Үүнд:

- ✓ Монгол Улсын нутаг дэвсгэр дээр
- ✓ Гадаад худалдааны түнш орнуудын нутаг дэвсгэр дээр
- ✓ Гадаад худалдаа эрхлэгч компанийн үйл ажиллагаанд гарч буй хүндрэл бэрхшээл


3.2.1 Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гардаг нийтлэг хүндрэл

Гадаад худалдаа эрхлэгчдэд улсын хил давахаас өмнө буюу Монгол Улсын нутаг дэвсгэр ямар нийтлэг хүндрэлүүд байгаа эсэхийг тодруулахад дотоодын тээвэрлэлт; гаалийн татвар; экспорт, импортын бичиг баримт бүрдүүлэхэд зарцуулах цаг хугацаа болон төлбөр хураамж; хил, гааль дээр хугацаа алдсанаас цаг хугацаа алдаж зардал нэмэгдэх зэрэг нь хамгийн хүндрэлтэй байдгийг хэлжээ. Тиймээс эдгээр хүндрэлүүдийг Улаанбаатар болон Монгол Улсын дөрвөн бүс нутаг, улсын дунджаар харьцуулан харуулсан болно.

3.2.1.1 Дотоодын тээвэрлэлт

Судалгаанд оролцогчдын 2 орчим хувь нь (Зураг 3.28) дотоодын тээвэрлэлтэд ямар нэг хүндрэл гардаггүй гэж хариулсан бол 21.8% нь тээвэрлэлтийн зардал маш өндөр, 18.9% нь тээвэрлэлтэд цаг хугацаа маш их зарцуулдаг, 17.2% нь хүртээмж бараг байхгүй гэж хариулжээ.

Зураг 3.28 Дотоодын тээвэрлэлтэд гарч буй хүндрэл (хувиар)



Дээрх зургаас харахад, судалгаанд оролцогчдын 55.8 хувьд нь тээвэрлэлтийн зардал, 53.8 хувьд нь тээвэрлэлтий цаг хугацаа, 43.5 хувьд нь тээврийн хэрэгслийн хүртээмж гадаад худалдаа эрхлэхэд нь ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байна. Иймд дотоодын тээвэрлэлтийн логистикийг хөгжүүлэх асуудал чухал болох нь харагдлаа.

Дотоодын тээвэрлэлтэд гарч буй дээрх хүндрэлүүдийг (маш их, их) Улаанбаатар болон Монгол улсын дөрвөн бүс нутаг, улсын дунджаар харьцуулахад дараах байдалтай байна.


Хүснэгт 3.15 Дотоодын тээвэр хийхэд гарч буй хүндрэл (бүс нутгаар, хувиар)

Хүндрэл	Улсын дүн	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар
Зардал	55.8	64.2	62.7	49.3	47.1	51.8
Цаг хугацаа	53.8	60.8	58.1	45.2	38.8	54.8
Хүртээмж	43.5	50.6	46.3	35.2	19.7	47.1

Тайлбар: Улаан өнгө- хамгийн их, ногоон – хамгийн бага хүндрэл учруулдаг.

Хүснэгт (3.15)-ээс харахад, гадаад худалдаа эрхлэгчдэд тээврийн зардал хамгийн их хүндрэл үүсгэж байгаа бөгөөд төвөөс алслагдмал Баруун бүсийн хувьд бүх үзүүлэлт хамгийн муу, түүний дараа Хангайн бүс орж байна. Иймээс эдгээр бүсүүдэд тээврийн дэд бүтцийг нэн түрүүнд хөгжүүлэх шаардлагатай гэж үзлээ. Дээрх хүндрэлүүд нь гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд дараах байдалтай байна.


Зураг 3.29 Дотоодын тээвэр хийхэд гарч буй хүндрэл (ААН-ийн хөрөнгө оруулалтын хэлбэрээр, хувиар)



3.2.1.2 Гаалийн татвар

Гадаад худалдаа эрхлэгчдэд учирдаг томоохон бэрхшээлүүдийн нэг нь гаалийн татвар бөгөөд судалгаанд оролцогчдын 7.2% нь импортын гаалийн татвар хүндрэл бараг үүсгэдэггүй гэж хариулсан бол 37% нь дунд зэрэг, 55.7% нь ихээхэн хүндрэл үүсгэж байгааг хэлжээ.

Зураг 3.30. Гаалийн татвараас үүсч буй хүндрэл (хувиар)




Хэдийгээр Монгол улс Азидаа импортын татвар хамгийн бага улсын тоонд ордог ч татвар нь бизнест хүндрэл учруулж байна гэдэг нь гаалийн тарифын зохицуулалтын үүргийг нэмэгдүүлэх нь чухал гэдгийг харуулж байж болох юм.

Хэдийгээр сүүлийн жилүүдэд гаалийн тарифын зохицуулалтын үүргийг нэмэгдүүлэх зорилготой томоохон бодлогын бичиг баримтууд гарч, гаалийн тариф, татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлтүүд орсон ч хэрэгжилт төдийлөн сайн байж чадахгүй байгааг уг судалгаа харуулж байна.

Гаалийн татвар голчлон аль бүс нутагт илүү хүндрэл учруулж байгааг тодруулах зорилгоор судалгаанд оролцогчдын маш их болон их хүндрэл учруулдаг гэсэн хариултыг нэгтгэж, Улаанбаатар болон Монгол улсын дөрвөн бүс нутаг, улсын дунджаар харьцуулан дараах зураг 3.31-т харуулав.

Зураг 3.31 Гаалийн татвараас үүдэн гарч буй хүндрэл, бүс нутгаар (хувиар)



Дээрх зургаас Зүүн бүсээс бусад бүсүүд импортын гаалийн татварыг гадаад худалдаа эрхлэхэд ихээхэн хүндрэл үүсгэдэг гэж 50-аас дээш хувь нь үнэлжээ. Ийм үр дүн гарахад “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” УИХ-ын 1999 оны 27 дугаар тогтоолын хавсралтад 2015 оноос хэд хэдэн нэмэлт өөрчлөлт оруулсан нь нөлөөлсөн байхыг үгүйсгэхгүй.

Дотоодод үйлдвэрлэх боломжтой зарим нэр төрлийн бараанд мөрдөж байсан импортын гаалийн тарифын 5 хувийн түвшинг ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтын тарифын дээд хязгаарт хүргэж нэмэгдүүлсэн. Тухайлбал,

- ✓ 2015 оны 8 дугаар сард мах, дайвар мах, зөгийн бал, нөөшилсөн бүтээгдэхүүн, цемент, троллейбусны гаалийн тарифын хувь, хэмжээг нэмэгдүүлсэн¹.
- ✓ 2016 оны 3 дугаар сарын 1-ээс импортын архи, дарсны гаалийн тарифыг нэмэгдүүлж цагаан архинд 40 хувь, дарсанд 20 хувийн гаалийн татвар ногдуулсан². Үүний зэрэгцээ Монгол Улс ДХБ-ын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Онцгой албан татварын тухай хуульд 2016 оны 2 сард нэмэлт, өөрчлөлт оруулж импортын болон дотоодын үйлдвэрийн архи, дарсанд ногдуулж байсан ялгавартай татварыг ижилтгэсэн³.
- ✓ 2016 оны 5 дугаар сарын 1-ээс дотоодод үйлдвэрлэх боломжтой 100 гаруй барааны гаалийн тарифын хувь, хэмжээг нэмэгдүүлсэн⁴ гэх мэт.

Гаалийн тарифын дээрх өөрчлөлтүүд нь богино хугацаанд тухайн барааны импортлогчдод хүндрэл үүсгэж болох хэдий ч урт хугацаанд дотоодын үйлдвэрлэлд эергээр нөлөөлж, эцсийн үр дүн ашигтай гарвал тарифын бодлогыг зөв хэрэгжүүлсэн гэж үзэж болно. Тиймээс тарифын бодлогын үр нөлөөнд эдийн засгийн тооцоо, судалгаа хийж үр дүнг тооцох нь чухал.

Харин экспортын татварын хувьд “Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хууль”-иар Бөөрөнхий мод, гуалин; Дүнз; Зүсмэл материал зэрэг 3 төрлийн бараанд экспортын татвартай ч импортынхоос дутахгүй хүндрэл үүсгэдэг гэж хариулсан. Ялангуяа Баруун бүс болон Улаанбаатарын гадаад худалдаа эрхлэгчдийн 50-аас дээш хувь нь экспортын татвар ихээхэн хүндрэл үүсгэдэг гэж үзжээ.

3.2.1.3 Экспорт, импортын бичиг баримт бүрдүүлэхэд гардаг хүндрэл

2013 оноос өмнө иргэд гадаад худалдаа эрхлэхийн тулд арав гаруй бичиг баримт бүрдүүлж, нэг сар гаруй хөөцөлддөг байсан. Энэхүү хүндрэлийг багасгах замаар гадаад худалдааг хөнгөвчлөх зорилготой 2012 онд Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэх; тээврийн бичиг баримт; тарифын бус хязгаарлалтад хамаарах барааны зөвшөөрөл лиценз; хууль тогтоомжид тусгайлан заасан бараанд мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон дүгнэлт гэсэн дөрвөн бичиг баримтыг шаардах болсон. Эдгээрээс эхний хоёр нь үндсэн бичиг баримтад тооцогддог тул бүх гадаад худалдаа эрхлэгчид энэ хоёр бичиг баримтад анхаарах хэрэгтэй.

Түүнчлэн Япон улстай Эдийн Засгийн Түншлэлийн Хэлэлцээр байгуулсантай холбоотой 2015 онд дээрх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж “...Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу эрх бүхий этгээд шаардсан тохиолдолд гарал үүслийг нотлох баримт бичиг”-ийг нэмсэн.

1 2015.08. 17-ний өдрийн 332 дугаар тогтоол


2 2016.02. 04-ний өдрийн 17 дугаар тогтоол

3 Онцгой албан татварын тухай Монгол Улсын хууль, 2006

4 2016.03. 28-ны өдрийн 185 дугаар тогтоол

Судалгаанд оролцогчдын 53% нь хууль тогтоомжид тусгайлан заасан бараанд мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон дүгнэлтийг, 50% нь импортын гарал үүслийн гэрчилгээ⁵ болон тээврийн баримтыг, 49% нь гадаад худалдааны гэрээг, 48% нь тарифын бус хязгаарлалтад хамаарах барааны зөвшөөрлийг хамгийн их хүндрэл үүсгэдэг (Зураг 3.32) гэжээ.

Зураг 3.32 Экспорт, импортын бичиг баримт бүрдүүлэхэд гардаг хүндрэл (хувиар)



Дээрх бичиг баримт бүрдүүлэхэд аль бүс нутагт илүү хүндрэл учруулж байгааг тодруулах зорилгоор судалгаанд оролцогчдын маш их болон их хүндрэл учруулдаг гэсэн хариултыг нэгтгэж, бүс нутаг, улсын дунджаар харьцуулан дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3.16 Экспорт, импортын бичиг баримт бүрдүүлэхэд гардаг хүндрэл (бүс нутгаар, хувиар)

Бүс нутаг	Мэргэжлийн хяналтын дүгнэлт	Гарал үүслийн гэрчилгээ	Тарифын бус хязгаарлалтад хамаарах барааны зөвшөөрөл	Тээврийн баримт	Гадаад худалдааны гэрээ
Баруун бүс	62	56	52	58	53
Улаанбаатар	57	46	46	47	48
Улсын дүн	53	50	48	50	49
Хангайн бүс	44	50	46	49	50
Төвийн бүс	41	47	53	45	52
Зүүн бүс	38	52	33	56	33


Тайлбар: Улаан өнгө- хамгийн их, ногоон – хамгийн бага хүндрэл учруулдаг.

⁵ Япон Улсаас гарал үүсэлтэй барааны гаалийн татварыг чөлөөлөх, бууруулах зорилгоор импортын бараанд гарал үүслийг нотлох баримт бичгийг шаардах болсон. Гэтэл импортлогчид бараандаа энэхүү баримтыг бүрдүүлээгүйн улмаас гаалийн татварын хөнгөлөлт эдлэх байтугай 2016 оны Импортын барааны гарал үүслийн дүрмийн 3.4-ийн “Импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиггүй бол ердийн тариф хэрэглэнэ” гэсэн заалтын дагуу өндөр татвар төлөхөд хүрч байсан нь ихээхэн хүндрэл үүсгэж байжээ.

Хүснэгт (3.16)-ээс харахад, Баруун бүсийн гадаад худалдаа эрхлэгчдэд бичиг баримт бүрдүүлэхэд хамгийн их хугацаа шаардаж хүндрэл үүсгэдэг гэж үзсэн. Ялангуяа Мэргэжлийн хяналтын дүгнэлт улсын дундаж дүнгээс бараг 10% өндөр байгаа нь ихээхэн анхаарал татсан үзүүлэлт байна.


Экспорт, импортын бичиг баримт бүрдүүлэхэд зарцуулах цаг хугацааны хүндрэл нь хөрөнгө оруулалтын хэлбэрээсээ хамааран ямар онцлогтой байгаа эсэхийг авч үзэхэд Гарал үүслийн гэрчилгээ болон Мэргэжлийн хяналтын дүгнэлт гадаадын хөрөнгө оруулалттай ААН-н хувьд хамгийн их хүндрэл үүсгэдэг бол дотоодын хөрөнгө оруулалттай ААН-н хувьд Мэргэжлийн хяналтын дүгнэлт хамгийн их бусад нь ижил түвшинд хүндрэл үүсгэдэг аж.

Зураг 3.33 Экспорт, импортын бичиг баримт бүрдүүлэхэд гардаг хүндрэл (ААН-н хөрөнгө оруулалтын хэлбэрээр, хувиар)




Гадаад худалдаа эрхлэгчдийн компанийн хэмжээ болон үйл ажиллагаа явуулсан хугацааны хувьд баримт бичгийн бүрдүүлэлт дээр ямар нэг ялгаа байгаа эсэхийг тодруулж дараах зураг (3.34, 3.35)-уудад харуулав.

Зураг 3.34 Экспорт, импортын бичиг баримт бүрдүүлэхэд гардаг хүндрэл (ААН-н хэмжээгээр, хувиар)



Зураг 3.35 Экспорт, импортын бичиг баримт бүрдүүлэхэд гардаг хүндрэл байгуулагдсан хугацаагаар (хувиар)




Дээрх зургаас харахад, эдгээр бичиг баримтыг бүрдүүлэхэд том ААН-н 56.2% нь дунд зэрэг хүндрэл гардаг гэсэн бол жижиг ААН-н 49.8%, дундаж ААН-н 51.7% нь ихээхэн хүндрэл үүсгэдэг гэжээ.

3.2.1.4 Хил, гааль дээр хугацаа алддаг, зардал нэмэгддэг эсэх

Хил, гаалийн үйлчилгээний (гааль, хилийн хяналт, мэргэжлийн хяналт, хорио цээр гэх мэт) чанар, хугацаа, хялбаршуулалт нь Логистикийн гүйцэтгэлийн индексийн нэг чухал үзүүлэлт юм. Монгол улс 2016 онд энэ үзүүлэлтээр 100 дугаар байранд 2.39 оноогоор⁶ жагссан нь 2014 онтой (132-р байр, 2.2 оноо) харьцуулахад 32 байраар урагшилжээ⁷.

Тэгвэл энэхүү судалгаанд оролцогсдоос гадаад худалдаа эрхлэхэд хил, гааль дээр хугацаа алддаг, үүнээс болж зардал нэмэгддэг эсэхийг тодруулахад дараах (Зураг 3.35) байдлаар хариулжээ.

Зураг 3.36 Хил, гааль дээр хугацаа алддаг, зардал нэмэгддэг эсэх (хувиар)



Дээрх зургаас үзэхэд, гадаад худалдаа эрхлэгчдийн 3-5% нь хил, гааль дээр ямар нэг хүндрэлгүй гэсэн бол 50 гаруй хувь нь хил, гааль дээр хугацаа алдсанаас цаг хугацааны болон зардлын ихээхэн хүндрэл үүсдэг гэж боомтууд дээр нийтлэг хариулт өгснөөс хил, гаалийн нэгдсэн зохицуулалт хангалтгүй байгааг харуулж байна гэж үзлээ.


6 Сингапур 4.18 оноогоор I байрт жагссан.
7 <http://ipi.worldbank.org/international/global/2016>

Экспорт, импортын бичиг баримт бүрдүүлэхэд зарцуулах цаг хугацааны хүндрэл үүсдэг эсэхийг тодруулсан асуултад Мэргэжлийн хяналтын дүгнэлтийг хамгийн их хүндрэл үүсгэдэг гэж хариулж байсан бол энэ асуултанд Мэргэжлийн хяналтын байгууллагыг бизнес эрхлэгчдэд хүндрэл чирэгдэл учруулахгүйгээр хяналт шалгалтаа явуулах хэрэгтэй гэдгийг онцолжээ. Мөн хил, гааль дээрх хяналтын тоног төхөөрөмж, лабораторийн болон хил нэвтрэх чадавхийг нэмэгдүүлэхэд Засгийн газраас шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байгааг дурдсан.

3.2.2 Гадаад худалдааны түнш орнуудын нутаг дэвсгэр дээр гардаг нийтлэг хүндрэл

Гадаад худалдаа эрхлэгчдэд улсын хил давсны дараа буюу бусад орны нутаг дэвсгэр ямар нийтлэг хүндрэлүүд байгаа эсэхийг тодруулахад түнш орны Импортын гаалийн татвар; Стандарт, хорио цээр; Транзит тээврийн зардал; Хил, гааль дээр хугацаа алдсанаас цаг хугацаа алдах, зардал нэмэгдэх зэрэг нь хамгийн хүндрэлтэй гэж үзсэн ба дараах зураг 3.36-г дэлгэрэнгүй хариултыг нэгтгэн харуулав.

Зураг 3.37. Гадаад худалдааны түнш орнуудын нутаг дэвсгэр дээр гардаг нийтлэг хүндрэл (хувиар)



Дээрх зургаас үзэхэд, гадаад худалдаа эрхлэгчдийн 2 орчим хувь нь гадаад худалдааны түнш орнуудын нутаг дэвсгэр дээр ямар нэг хүндрэл гардаггүй гэсэн бол 54-57% нь ихээхэн хүндрэл учруулдаг гэж үзжээ. Хөрш орнуудын хил, гааль дээр хүндрэл учирч байгааг тодруулахад, судалгаанд оролцогчдын 57% нь ОХУ-ын, 55% нь БНХАУ-ын хил, гааль дээр ихээхэн хүндрэл үүсдэг гэж хариулсан.

Гадаад худалдааны түнш орнуудын нутаг дэвсгэр дээр гардаг нийтлэг хүндрэлийг бүс нутгууд хэрхэн үнэлснийг дараах хүснэгт 3.17-д улсын дундажтай харьцуулан харууллаа.

Хүснэгт 3.17 Гадаад худалдааны түнш орнуудын нутаг дэвсгэр дээр гардаг нийтлэг хүндрэл (бүс нутгаар, хувиар)

Бүс нутаг	Импортын гаалийн татвар	Стандарт, хорио цээр	Транзит тээврийн зардал	ОХУ	БНХАУ
Баруун бүс	63.8	61.1	60.6	58.4	59.3
Хангайн бүс	57.4	48.4	50	48.8	48.3
Улсын дүн	57.1	54.5	57.3	56.2	54.5
Улаанбаатар	56.6	57.8	57.3	58.7	54.7
Зүүн бүс	52.1	26.5	66.7	41.2	46.5
Төвийн бүс	49.5	56.6	57	63.8	57


Тайлбар: Гадаад худалдааны түнш орнуудын нутаг дэвсгэр дээр гардаг нийтлэг хүндрэлийн хувьд улаан өнгө- хамгийн их, ногоон – хамгийн бага хүндрэл учруулдаг.

Гадаад худалдааны түнш орнуудын нутаг дэвсгэр дээр гардаг нийтлэг хүндрэлүүдийг бүсээр авч үзэхэд, Баруун бүсийн хувьд Импортын гаалийн татвар, Стандарт, хорио цээр болон БНХАУ-ын хил, гааль дээр хамгийн их хүндрэл үүсдэг гэсэн бол Зүүн бүс транзит тээврийн зардал, Төвийн бүс ОХУ-ын хил гааль гэж хариулжээ. Дээрх хүндрэлийг даван туулахад, түнш орнуудын холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ байгуулан хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах нь чухал болов уу.

3.2.3 Гадаад худалдаа эрхлэгч ААН-н үйл ажиллагаанд гарч буй хүндрэл бэрхшээл

Гадаад худалдаа эрхлэхэд тухайн ААН-н чадавхи чухал үүрэгтэй бөгөөд энд ямар нийтлэг хүндрэлүүд байгаа эсэхийг тодруулахад Гадаад зах зээл дээр түншлэгч олох; Гадаад худалдааны гэрээ байгуулах чадвар; Чадварлаг ажиллах хүчний олдоц; Экспорт, импорт хийх талаар мэдээллийн олдоц; Хөрөнгө санхүүгийн олдоц; Түүхий эдийн олдоц, хүрэлцээ; Тоног төхөөрөмж, технологийн олдоц зэрэг нь хамгийн хүндрэлтэй (Зураг 3.37) байдгийг хэлжээ.


Зураг 3.38 Гадаад худалдаа эрхлэгч ААН-н үйл ажиллагаанд гарч буй хүндрэл бэрхшээл (хувиар)



Судалгаанд оролцогсдын хариултаас харахад, гадаад худалдаа эрхлэхэд үйл ажиллагаа талаасаа хүндрэл байхгүй гэж 2-3%, ихээхэн хүндрэл үүсгэдэг гэж 50 гаруй хувь нь үнэлсэн. Тэр дундаа экспорт, импорт хийх талаар мэдээллийн олдоц хамгийн муу гэж 57 орчим хувь нь хариулжээ. Тиймээс бусад улс орнуудын тодорхой салбар, бараа, бүтээгдэхүүн, зах зээлээр төрөлжин мэргэшсэн экспорт, импортын менежментийн компани ажиллуулдаг туршлагыг нэвтрүүлж, гадаад худалдаа эрхлэгчдэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх, бодитой мэдээллээр хангах зэрэг нь чухал юм.

Дээрх хүндрэлүүд бүс нутагт ямар байгааг улсын дундажтай харьцуулан зураг 3.38-д харуулав.


Зураг 3.39 Гадаад худалдаа эрхлэгч ААН-н үйл ажиллагаанд гарч буй хүндрэл бэрхшээл (бүс нутгаар)



Дээрх зургаас харахад, судалгаанд оролцогчдын 52-59% нь дээр дурдагдсан асуудлууд төвөөс алслагдсан Баруун болон Зүүн бүсэд ихээхэн хүндрэл учруулдаг гэж үзсэн ба хүндрэлийн зэрэг улсын дунджаас дээгүүр байгаа юм. Тухайлбал, гадаад зах зээл дээр түншлэгч олох, чадварлаг хүний нөөцийн олдоц болон гадаад худалдааны гэрээ байгуулах чадвар Баруун бүсэд, хөрөнгө санхүү, мэдээллийн болон тоног төхөөрөмж, технологийн олдоц Зүүн бүсэд хамгийн их хүндрэл учруулж байна.

Гадаад худалдаа эрхлэгч ААН-н хэмжээнээс хамааран дээрх хүндрэлүүд ялгаатай байгаа эсэхийг дараах зурагт үзүүлэв.


Зураг 3.40 Гадаад худалдаа эрхлэгч ААН-н үйл ажиллагаанд гарч буй хүндрэл бэрхшээл (ААН-н хэмжээгээр)



Дээрх зургаас харахад, чадварлаг хүний нөөц, гадаад худалдааны гэрээ болон гадаад зах зээл дээр түнш олох асуудал бүх түвшний ААН-д чухал байна. Чадварлаг хүний нөөцийн дутагдал дунд (60.4%) болон жижиг (55.6%) ААН-д илүү их хүндрэл учруулдаг бол гадаад худалдааны гэрээ том ААН-д (50%), гадаад зах зээл дээр түнш олох асуудал дундаж ААН-н хувьд хамгийн их хүндрэл үүсгэдэг гэжээ.

Гадаад худалдааны гэрээ нь гаалийн бүрдүүлэлтэд шаардлагатай үндсэн хоёр бичиг баримтын нэг. Түүнчлэн гэрээг хир сайн байгуулснаас гадаад худалдаа эрхлэгчийн ашиг, алдагдал шалтгаалдаг. Гэтэл зарим ААН гаалийн үнээ бууруулах зорилгоор хуурамч гэрээ байгуулах, гэрээ нь гаалийн мэдүүлгийн үнэн зөвийг баталж чадахгүй өөрөөр хэлбэл, үндсэн баримт бичгийн шаардлага хангахгүй байх зэрэг шалтгаанаас гааль дээр буцаагдах тохиолдолд эргээд гадаад худалдаа эрхлэгчдэд хүндрэл үүсгэх нь бий.

Зураг 3.41. Гадаад худалдаа эрхлэгч ААН-н үйл ажиллагаанд гарч буй хүндрэл бэрхшээл, (ААН-н хэмжээгээр, хувиар)



Дээрх зургаас харахад, экспорт, импортын мэдээллийн (62.6%) болон түүхий эдийн (56.3%) олдоц том ААН-н хувьд ихээхэн хүндрэл үүсгэж байгааг харуулж байна. Тиймээс дээр дурдсан Экспорт, импортын менежментийн компани манай улсын хувьд маш чухал гэдгийг нотолж байна.

Дунд хэмжээний ААН-н хувьд тоног төхөөрөмж, технологийн олдоц (55.9%), жижиг ААН-н хувьд хөрөнгө санхүү (57.2%) гадаад худалдаа эрхлэхэд хамгийн их хүндрэл учруулдаг гэжээ.

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. БИЗНЕСИЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ

4.1 Төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо

Судалгааны тайлангийн өмнөх бүлгүүдэд бизнесийн орчинд нөлөөлөх хүчин зүйлсэд үнэлгээ хийж бизнесийн орчны өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлсон бол энэхүү бүлэгт бизнесийн орчинг сайжруулах дэмжлэг болон саад болж буй субъектүүдэд үнэлгээг өгөхийн сацуу цаашид бизнесийн орчинг сайжруулах чиглэлд хийгдэх нэн тулгамдаж буй асуудлуудыг илрүүлэхийг гол зорилгоо болгов.

4.1.1 Бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлдэг субъектийн оролцооны түвшин, дэмжлэг чухал эсэх

Бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлдэг субъектийн оролцооны түвшинг 1-4 оноо (1-дэмжлэг байхгүй, 2—муу, 3-дунд, 4-сайн)- гоор үнэлүүлэн үнэлгээний коэффициентийг жигнэсэн дунджийн аргыг ашиглан тодорхойлов.


Бизнест дэмжлэг үзүүлж буй үндсэн 8 субъектээс хамгийн сайн үнэлэгдсэн нь МҮХАҮТ, арилжааны банкууд буюу дэмжлэг дунд хэмээсэн байхад бусад 6 субъектийн хувьд дэмжлэг муу үзүүлдэг гэж үнэлэгдсэн байна. Үнэлгээг бүсчилж авч үзвэл хамгийн сайн дэмжлэг үзүүлдэг байгууллагаар Улаанбаатар, Зүүн, Төвийн бүсэд МҮХАҮТ-ийг нэрлэсэн бол Баруун, Хангайн бүсэд арилжааны банкуудыг онцолжээ. Харин хамгийн муу дэмжлэг үзүүлж буй байгууллагыг Улаанбаатар хотод орон нутгийн засаг захиргаа хэмээсэн бол бусад бүсүүдэд төрийн бус байгууллагыг нэрлэсэн байна.

Бизнесийн дэмжлэг үзүүлдэг дээрх субъектүүдийн дэмжлэг хир чухал болохыг 1-3 оноо (1-шаардлагагүй, 2—чухал, 3-маш чухал)-гоор үнэлүүлэн үнэлгээний дундаж коэффициентийг тооцоолж үзэхэд Засгийн газрын болон Орон нутгийн засаг захиргааны байгууллагын дэмжлэг бусад байгууллагуудтай харьцуулахад хамгийн чухал хэмээсэн байна. Тодруулбал Улсын хэмжээнд судалгаанд оролцогсдын 59% нь Засгийн газрын, 56.2% нь Орон нутгийн засаг захиргааны, 52% нь арилжааны банкны, 50.7% нь МҮХАҮТ-н дэмжлэг маш чухал хэмээсэн бол Улаанбаатар хотын хувьд 51.5% нь Засгийн газрын дэмжлэг, Баруун бүсэд 61.2% нь Засгийн газрын, 58.6% нь орон нутгийн засаг захиргааны, 51.8% нь МҮХАҮТ, 50.9% нь арилжааны банкны дэмжлэг, Хангайн бүсэд 59.5% нь Засгийн газрын, 59.1% нь Орон нутгийн засаг захиргааны, 55.4% нь арилжааны банкны, 54.6% нь МҮХАҮТ-н дэмжлэг, Зүүн бүсэд 68.9% нь Орон нутгийн засаг захиргаа, 68.7% нь Засгийн газрын, 57.9% нь арилжааны банкны дэмжлэгийг маш чухал байна гэж хариулжээ.

Зураг 4.1. Бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлдэг субъектийн оролцооны түвшин (дээд утга -4)



Зураг 4.2 Бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлдэг субъектүүдийн дэмжлэг хэр чухал эсэх (дээд утга -3)



Хүснэгт 4.1 Бизнесийн дэмжлэг үзүүлдэг субъектийн оролцооны түвшин (дээд утга 4), дэмжлэг чухал эсэх (дээд утга 3), салбараар

№	Субъект	Худалдаа		Үйлчилгээ		Боловсруулах үйлдвэр		Үул уурхай		Барилга		Тээвэр		Мал аж ахуй		Газар тариалан		Мэдээллийн технологийн холбоо		Аялал жуулчлал	
		Дэмжлэг үзүүлдэг	Цаашид дэмжлэг чухал эсэх	Дэмжлэг үзүүлдэг	Цаашид дэмжлэг чухал эсэх	Дэмжлэг үзүүлдэг	Цаашид дэмжлэг чухал эсэх	Дэмжлэг үзүүлдэг	Цаашид дэмжлэг чухал эсэх	Дэмжлэг үзүүлдэг	Цаашид дэмжлэг чухал эсэх	Дэмжлэг үзүүлдэг	Цаашид дэмжлэг чухал эсэх	Дэмжлэг үзүүлдэг	Цаашид дэмжлэг чухал эсэх	Дэмжлэг үзүүлдэг	Цаашид дэмжлэг чухал эсэх	Дэмжлэг үзүүлдэг	Цаашид дэмжлэг чухал эсэх	Дэмжлэг үзүүлдэг	Цаашид дэмжлэг чухал эсэх
1	Засгийн газар	2.29	2.43	2.36	2.56	2.28	2.55	2.64	2.74	2.21	2.48	2.11	2.50	2.44	2.21	2.53	2.21	2.10	2.05	2.16	2.38
2	Орон нутгийн засаг захиргаа	2.34	2.40	2.34	2.56	2.45	2.57	2.59	2.71	2.11	2.39	2.28	2.60	2.46	2.38	2.46	2.46	2.17	2.25	2.33	2.50
3	Олон улсын байгууллагууд	2.25	2.24	2.32	2.35	2.24	2.37	2.48	2.33	2.09	2.29	2.16	2.33	2.39	2.05	2.54	2.05	2.35	2.05	2.20	2.53
4	Төрийн бус байгууллага	2.22	2.16	2.23	2.29	2.34	2.28	2.00	2.14	1.96	2.14	1.95	2.20	2.40	1.84	2.44	2.17	2.09	2.05	2.00	2.24
5	МУХАУТ	2.52	2.35	2.63	2.46	2.82	2.51	2.57	2.43	2.48	2.24	2.65	2.20	2.49	2.29	2.33	2.35	2.35	2.35	2.35	2.13
6	Үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн мэргэжлийн холбоод	2.30	2.22	2.32	2.36	2.38	2.41	2.43	2.05	2.35	2.35	2.11	2.13	2.40	2.00	2.43	2.09	2.05	2.11	2.12	2.12
7	Зөвлөгөө өгөх төвүүд	2.29	2.28	2.30	2.25	2.33	2.35	2.20	2.24	2.17	2.13	2.33	2.07	2.32	2.21	2.47	2.26	2.06	2.00	2.00	2.24
8	Арилжааны банкууд	2.55	2.34	2.60	2.49	2.70	2.55	2.50	2.42	2.19	2.18	2.22	2.43	2.53	2.62	2.35	2.45	2.30	2.24	2.24	2.47

Бизнесийн дэмжлэг үзүүлдэг дээрх субъектүүдийн дэмжлэг үзүүлж буй эсэх болон цаашид дэмжлэг хир чухал болохыг салбар тус бүрээр тодотгож хүснэгтэд авч үзвэл худалдаа, МАА, газар тариалан, харилцаа холбооны салбарынхны хувьд Арилжааны банкууд, үйлчилгээ аялал жуулчлал, боловсруулах үйлдвэр, барилга, тээврийн салбарт МҮХАҮТ, уул уурхайн салбарын хувьд Засгийн газар хамгийн их дэмжлэг үзүүлдэг субъектээр нэрлэгдсэн бол цаашид Засгийн газар, Орон нутгийн засаг захиргааны дэмжлэг ихээхэн хэрэгцээтэй хэмээн дийлэнх салбарын бизнес эрхлэгчид үзжээ.



4.1.2 Бизнесийн хөгжилд үзүүлж буй төрийн байгууллагын саад

Аж ахуйн нэгжүүдийн бизнесээ өргөжүүлэн хөгжүүлэхэд төрийн байгууллагууд саад учруулдаг эсэхийг 1-5 оноо (1-хамгийн их, 2–их, 3-дунд зэрэг, 4-бага, 5-саад болдоггүй)- гоор үнэлүүлэн үнэлгээний коэффициентийг тодорхойлж доорх хүснэгтэд харуулав. Бизнесийн хөгжилд саад болж буй төрийн байгууллагуудад өгсөн үнэлгээг боломжит дээд утга болох 5 оноотой харьцуулан зураглан бүсүүдээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 4.2 Бизнес хөгжүүлэлт дэх төрийн байгууллагын саад (бүсээр)

№	Байгууллага	Улсын хэмжээнд	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаан-баатар
1	Татварын байгууллага	2.40	2.50	2.57	2.73	2.84	2.43
2	Мэргэжлийн хяналтын байгууллага	2.50	2.60	2.67	2.76	3.17	2.44
3	Яам, тамгын газар	2.56	2.54	2.84	2.93	3.18	2.46
4	Орон нутгийн засаг захиргаа/нийслэл, дүүргийн захиргаа	2.67	2.58	2.81	2.97	3.33	2.62
5	Гаалийн байгууллага	2.74	2.69	3.00	2.99	3.28	2.62
6	Хил боомтын байгууллага	2.77	2.71	2.98	3.00	3.39	2.71
7	Газрын алба	2.79	2.71	2.92	3.10	3.69	2.65
8	Санхүүгийн зохицуулах хороо	3.03	3.00	3.15	3.29	3.71	2.85
9	Бүртгэлийн байгууллага (компанийн/иргэний/ хөрөнгийн)	3.03	2.95	3.11	3.30	3.88	2.86
10	Стандартчлал хэмжил зүйн газар	3.09	3.06	3.14	3.27	3.82	2.95
11	Хот төлөвлөлтийн газар	3.10	3.02	3.20	3.39	3.82	2.94
12	Цагдаагийн байгууллага	3.12	3.05	3.24	3.33	3.82	2.99

Зураг 4.3 Бизнесийн хөгжүүлэлт дэх төрийн байгууллагын саад (бүс нутгаар, дээд утга 5)



Байгууллагын бизнесээ өргөжүүлэн хөгжүүлэхэд хамгийн ихээр саад болдог төрийн байгууллагыг бүсийн ялгаагүйгээр Татварын байгууллагыг нэрлэсэн байна. Татварын байгууллагын мэргэжилтнүүдийн харилцаа муу (судалгаанд оролцогсдын 24.7%), авилга хээл хахууль (судалгаанд оролцогсдын 21.3%) нь бизнест хамгийн ихээр саад болж байна хэмээн судалгаанд оролцогсад үзжээ. (Хүснэгт 4.3)





Татварын байгууллагын дараа мэргэжлийн хяналтын байгууллагыг бизнест саад болдог хэмээн улсын хэмжээнд болон баруун бүсээс бусад бүсэд үзсэн бөгөөд тус байгууллагын мэргэжилтнүүдийн харилцаа муу (судалгаанд оролцогсдын 27.6%), авилга хээл хахууль (судалгаанд оролцогсдын 23.4%)-ийг хамгийн их саад болж буй хүчин зүйлээр нэрлэжээ. Харин яам, тамгын газрыг улсын хэмжээнд болон төв, зүүн, УБ хотод гуравдугаарт, баруун бүсэд хоёрдугаарт авч үзсэн ба тэдний мэргэжилтнүүдийн харилцаа муу (судалгаанд оролцогсдын 26.8%), авилга хээл хахууль (судалгаанд оролцогсдын 20.5%), мэргэжилтний мэдлэг ур чадвар муу (судалгаанд оролцогсдын 19.6%) зэрэг нь бизнест сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлс гэж онцолсныг анхаарах шаардлагатай.


Хүснэгт 4.3 Бизнес хөгжүүлэлтэд төрийн байгууллагын саад болж буй хүчин зүйлс

Байгууллагын нэр	Мэргэжилтнүүдийн		Авлига хээл хахуул	Дүрэм журмын ойлгомжгүй байдал	Хүнд суртал	Нэгж, албад хоорондын уялдаа холбоо муу
	мэдлэг, ур чадвар муу	харилцаа муу				
Яам, тамгын газар	19.6	26.8	20.5	14.2	12.4	5.0
Аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргаа	20.0	25.9	16.5	13.5	15.5	6.9
Гаалийн байгууллага	13.9	26.4	31.0	10.5	10.4	5.5
Хил боомтын байгууллага	13.5	24.9	28.5	14.4	9.8	6.7
Мэргэжлийн хяналтын байгууллага	13.6	27.6	23.4	16.2	11.5	6.1
Татварын байгууллага	13.9	24.7	21.3	17.6	12.0	7.1
Санхүүгийн зохицуулах хороо	16.1	22.6	20.5	17.5	10.1	8.4
Стандартчилал, хэмжил зүйн газар	14.3	21.3	17.8	21.4	10.7	9.1
Газрын алба	14.9	23.9	26.1	11.6	12.9	6.8
Бүртгэлийн байгууллага (компанийн/иргэний/хөрөнгийн)	14.4	24.7	18.3	15.7	14.2	8.5
Цагдаагийн байгууллага	13.4	32.8	18.8	12.4	12.4	6.2

Бизнес хөгжүүлэлтэд төрийн байгууллагын саад болж буй гол хүчин зүйлсийн үнэлгээг бүс тус бүрээр зураглан авч үзвэл дараах байдалтай байна.

Зураг 4.4 Бизнес хөгжүүлэлтэд төрийн байгууллагын саад болж буй гол хүчин зүйлс (хувийн жин, бүс нутгаар)





Аж ахуйн нэгжүүдийн бизнесээ өргөжүүлэн хөгжүүлэхэд төрийн байгууллагууд саад учруулдаг эсэхийг салбараар тодруулан авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 4.5 Бизнесийн хөгжүүлэлт дэх төрийн байгууллагын саад (салбараар, дээд утга 5)

№	Байгууллага	Худалдаа	Үйлчилгээ	Боловсруулах үйлдвэр	Уул уурхай	Барилга	Тээвэр	Мал аж ахуй	Газар тариалан	Мэдээлэл технологи харилцаа холбоо	Аялал жуулчлал
1	Яам, тамгын газар	2.76	2.73	2.82	2.64	2.76	2.88	2.83	2.77	2.43	2.60
2	Орон нутгийн засаг захиргаа/ нийслэл, дүүргийн захиргаа	2.82	2.77	2.91	2.73	2.67	2.94	3.05	2.95	2.74	2.48
3	Гаалийн байгууллага	2.73	3.10	2.90	3.05	3.00	2.53	3.19	3.11	2.90	2.26
4	Хил боомтын байгууллага	2.79	3.11	2.89	3.14	3.16	2.65	3.22	3.06	3.05	1.94
5	Мэргэжлийн хяналтын байгууллага	2.63	2.77	2.69	2.91	2.63	2.50	2.65	2.51	2.83	1.86
6	Татварын байгууллага	2.60	2.52	2.62	3.05	2.55	2.74	2.66	2.49	2.39	1.95
7	Санхүүгийн зохицуулах хороо	3.04	3.24	3.11	3.43	3.14	3.44	3.40	3.39	2.64	2.69
8	Стандартчлал хэмжил зүйн газар	3.11	3.18	3.29	3.55	3.18	3.16	3.36	3.35	3.18	2.84

9	Газрын алба	2.87	2.92	3.00	3.27	2.73	3.22	3.16	3.16	2.91	3.05
10	Бүртгэлийн байгууллага (компанийн/иргэний/хөрөнгийн)	3.04	3.16	3.25	3.81	3.08	3.44	3.41	3.22	2.96	3.35
11	Цагдаагийн байгууллага	3.08	3.28	3.40	3.45	3.47	3.39	3.59	3.22	3.05	3.00
12	Хот төлөвлөлтийн газар	3.14	3.15	3.25	3.68	2.98	3.44	3.47	3.66	3.00	3.11

Салбараар авч үзвэл худалдаа, үйлчилгээ, боловсруулах үйлдвэр, барилга, газар тариалан, харилцаа холбооны салбарынхан Татварын байгууллагыг, тээвэр, мал аж ахуй, аялал жуулчлалын салбарынхан Мэргэжлийн хяналтын байгууллагыг, харин уул уурхайн салбарынхан Яам, тамгын газрыг бизнест саад ихээр учруулдаг байгууллагаар нэрлэсэн байна.

4.1.3 Төрийн болон төрийн бус байгууллагуудаас хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээнүүд бизнест дэмжлэг болсон эсэх

Бизнесийг дэмжих бодлогын хүрээнд сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь бизнест дэмжлэг болсон эсэхийг 1-5 оноо (1-огт дэмжлэг болоогүй, 2–бага дэмжлэг болсон, 3-дэмжлэг болсон, 4-сайн дэмжлэг болсон, 5-маш сайн дэмжлэг болсон)- гоор үнэлүүлэн үнэлгээний коэффициентийг жигнэсэн дунджийн аргыг ашиглан дараах хүснэгтэд тодорхойлов.

Хүснэгт 4.6 Бизнесийг дэмжих чиглэлд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь бизнест дэмжлэг болсон эсэх (бүс нутгаар)

Дэмжлэгийн хэлбэр	Улсын хэмжээнд	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаан баатар
Төрийн байгууллагын нэг цэгийн үйлчилгээ	2.99	3.00	2.95	2.91	2.86	3.12
Төрийн үйлчилгээний цахимжуулалт	2.98	2.99	2.92	2.94	2.82	3.11
Үзэсгэлэн худалдаа	2.97	3.17	2.95	2.92	2.87	2.90
Дэд бүтцийн хөгжүүлэлт	2.95	2.96	2.95	2.96	2.73	3.02
Сургалт зөвлөгөө	2.93	3.03	2.95	2.85	2.94	2.91
Чуулга уулзалт	2.79	2.92	2.75	2.82	2.70	2.74
Татварын хөнгөлөлт	2.66	2.78	2.55	2.78	2.23	2.74
НӨАТ-ын буцаан олголт	2.55	2.65	2.48	2.47	2.39	2.66
Ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт	2.54	2.68	2.46	2.51	2.13	2.70
Импортын гаалийн тарифыг өсгөсөн нь үндэсний үйлдвэрлэлд дэмжлэг болсон эсэх	2.53	2.59	2.41	2.56	2.36	2.60

Хяналтын хуудас (Мэргэжлийн хяналтын байгууллагаас хяналт хийхдээ ашигладаг)	2.49	2.62	2.42	2.41	2.41	2.53
Хөрөнгө оруулалтын урамшууллын бодлого	2.42	2.53	2.23	2.43	2.22	2.55
Бондын санхүүжилт	2.27	2.29	2.12	2.30	1.93	2.49

Үндэсний хэмжээнд авч үзвэл төрийн байгууллагын нэг цэгийн үйлчилгээ, төрийн үйлчилгээний цахимжуулалт, үзэсгэлэн худалдаа, дэд бүтцийн хөгжүүлэлт, сургалт зөвлөгөө зэрэг нь бизнест дэмжлэг болж чадсан хэмээн бүх бүсэд ижил үзсэн буюу нийт судалгаанд оролцогсдын 32-37% нь дэмжлэг болсон, 20 орчим хувь нь сайн дэмжлэг болсон, 10-18% нь маш сайн дэмжлэг болсон гэжээ. Түүнчлэн чуулга уулзалт, татварын хөнгөлөлт, НӨАТ-ын буцаан олголт, Ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, зарим барааны импортын гаалийн тарифыг өсгөсөн зэрэг нь бизнест тодорхой хэмжээнд эерэг дэмжлэг болж чадсан байна. Харин эдгээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс хамгийн өндөр өртөгтэй Бондын санхүүжилт нь хамгийн бага үнэлгээг авсан буюу бизнест бага дэмжлэг болсон хэмээн судалгаанд оролцогсад үзжээ.

Бүс тус бүрээр тодруулж үзвэл, Баруун бүсийн хувьд улсын хэмжээний үр дүнтэй ижил бондын санхүүжилтийг огт дэмжлэг болоогүй гэж судалгаанд оролцогчдын 48,5% нь, цаашлаад 26% нь хяналтын хуудас (мэргэжлийн хяналтынхан шалгалт хийхдээ ашигладаг), 32,7% нь хөрөнгө оруулалтын урамшууллын бодлого, 25,8% нь импортын гаалийн татварыг өсгөсөн, 23,6% нь НӨАТ-ын буцаан олголт, 23,3% нь ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, 21,3% нь татварын хөнгөлөлтийн дэмжлэгийг огт дэмжлэг болоогүй гэж хариулсан бол 20 хүрэхгүй хувь нь хяналтын хуудас, хөрөнгө оруулалтын урамшууллын бодлого, импортын гаалийн тарифийг өсгөсөн, НӨАТ-ын буцаан олголт, ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, бондын санхүүжилт, татварын хөнгөлөлт гэх дэмжлэгүүдийг сайн дэмжлэг болсон гэж хариулжээ. Харин төрийн байгууллагын нэг цэгийн үйлчилгээ, төрийн үйлчилгээний цахимжуулалт, дэд бүтцийн хөгжүүлэлт, үзэсгэлэн худалдаа, сургалт зөвлөгөөн, чуулга уулзалт, бусад дэмжлэг зэргийг 32-45% нь дэмжлэг болсон гэж үзсэн бөгөөд 20 орчим хувь нь сайн дэмжлэг болсон, 10-18% нь маш сайн дэмжлэг болсон гэж үзсэн байна.

Хангайн бүсийн хувьд 30-40% нь чуулга уулзалт, сургалт зөвлөгөө, үзэсгэлэн худалдаа, дэд бүтцийн хөгжүүлэлт, төрийн үйлчилгээний цахимжуулалт, төрийн байгууллагын нэг цэгийн үйлчилгээ, хяналтын хуудас, импортын гаалийн тарифыг өсгөсөн нь, НӨАТ-ын буцаан олголт, татварын хөнгөлөлт зэргийг дэмжлэг болсон гэж үзсэн. Харин 36,1% нь хөрөнгө оруулалтын урамшууллын бодлого, 44% нь бондын санхүүжилтын дэмжлэг огт дэмжлэг болж чадаагүй гэжээ. 20-30% нь чуулга уулзалт, сургалт зөвлөгөө, үзэсгэлэн худалдаа, дэд бүтцийн хөгжүүлэлт, төрийн үйлчилгээний цахимжуулалт, төрийн байгууллагын нэг цэгийн үйлчилгээ гэсэн дэмжлэгүүдийг сайн дэмжлэг болсон гэж дүгнэсэн байна.

Төвийн бүсийн хувьд бондын санхүүжилтээс бусад бүх дэмжлэгүүдийг дэмжлэг болж чадсан гэж 31-42% нь хариулсан байгаа нь энэ бүс нутгийн бизнес эрхлэгчид төрийн болон төрийн бус байгууллагуудын дэмжлэгт харьцангуй сэтгэл ханамжтай

байна гэж дүгнэж болохоор байна. Харин 27,9% нь хяналтын хуудас, 29% нь хөрөнгө оруулалтын урамшууллын бодлого, 25,3% нь импортын гаалийн татвар тарифыг өсгөсөн, 26,1% нь НӨАТ-ын буцаан олголт, 27,6% нь ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, 23,3% нь татварын хөнгөлөлтийн дэмжлэгийг огт дэмжлэг болоогүй гэж хариулжээ.

Зүүн бүсийн хувьд 28,3% нь хяналтын хуудас, 41,2% нь хөрөнгө оруулалтын урамшууллын бодлого, 33,3% нь импортын гаалийн тарифыг өсгөсөн үр дүн, 35,6% нь НӨАТ-ын буцаан олголт, 44,3% нь ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, 57,8% нь бондын санхүүжилт, 42,6% нь татварын хөнгөлөлтийн дэмжлэгүүдийг огт дэмжлэг болоогүй гэж үзсэн нь бусад бүстэй харьцуулахад бизнес эрхлэгчид эдгээр арга хэмжээнүүдэд харьцангуй сэтгэл ханамжгүй байгаа нь харагдаж байна. 41,7% нь чуулга уулзалт, 29,4% нь сургалт зөвлөгөө, 37% нь үзэсгэлэн худалдаа, 39,1% нь дэд бүтцийн хөгжүүлэлт, 34,2% нь төрийн үйлчилгээний цахимжуулалт, 38,7% нь төрийн байгууллагын нэг цэгийн үйлчилгээ, 35,8% нь хяналтын хуудас зэрэг дэмжлэгийг дэмжлэг болж чадсан гэж үзсэн байна.

Улаанбаатар хотын хувьд бусад бүсүүдтэй харьцуулахад байгууллагууд нь төрийн болон төрийн бус байгууллагуудын дэмжлэгт сэтгэл ханамжтай байдаг нь судалгаанаас харагдлаа. Тодруулбал бусад бүсийн хувьд маш сайн дэмжлэг болсон гэх хариулт нь 20%-д хүрэхгүй дийлэнх нь 10 орчим хувьтай байсан бол Улаанбаатар хотын хувьд 10-25% нь маш сайн дэмжлэг болсон гэж бүх дэмжлэг дээр нэгэн жигд хариулсан байна. 30-50% нь дээрх арга хэмжээнүүдийг дэмжлэг болж чадсан гэж дүгнэсэн бол огт дэмжлэг болоогүй үзүүлэлтээр 29,9% нь хяналтын хуудас, 34,4% нь хөрөнгө оруулалтын урамшууллын бодлого, 29,7% нь импортын гаалийн татварыг өсгөсөн, 27,8% нь НӨАТ-ын буцаан олголт, 27,1% нь ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, 39,8% нь бондын санхүүжилт, 25,4% нь татварын хөнгөлөлтийн дэмжлэгүүдийг нэрлэсэн байна.

Төрийн болон төрийн бус байгууллагуудаас хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээнүүд бизнест дэмжлэг болсон эсэхийг салбараар тодруулан харвал дараах байдалтай байна.

Хүснэгт 4.7 Бизнесийг дэмжих чиглэлд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь бизнест дэмжлэг болсон эсэх (салбараар, дээд утга 5)

№	Дэмжлэг үзүүлэлт	Худалдаа	Үйлчилгээ	Боловсруулах үйлдвэр	Уул уурхай	Барилга	Тээвэр	Мал аж ахуй	Газар тариалан	Мэдээлэл технологи харилцаа холбоо	Аялал жуулчлал
1	Татварын хөнгөлөлт	2.74	2.47	2.77	2.75	2.58	2.21	2.58	2.72	2.41	2.32
2	Бондын санхүүжилт	2.35	2.14	2.35	2.35	2.38	1.84	2.35	1.94	2.14	1.81

3	Ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт	2.60	2.52	2.66	2.75	2.41	2.00	2.49	2.34	2.52	2.12
4	НӨАТ-ын буцаан олголт	2.59	2.53	2.63	2.60	2.61	1.95	2.41	2.24	2.40	2.24
5	Импортын гаалийн тарифыг өсгөсөн нь үндэсний үйлдвэрлэлд дэмжлэг болсон эсэх	2.59	2.50	2.58	2.50	2.53	1.94	2.41	2.59	2.00	2.13
6	Хөрөнгө оруулалтын урамшууллын бодлого	2.52	2.27	2.52	2.58	2.57	1.84	2.34	2.28	2.00	1.81
7	Хяналтын хуудас (Мэргэжлийн хяналтын байгууллагаас хяналт хийхдээ ашигладаг)	2.56	2.42	2.61	2.42	2.33	1.74	2.32	2.34	2.25	2.19
8	Төрийн байгууллагын нэг цэгийн үйлчилгээ	3.01	2.95	3.12	3.15	2.76	2.89	2.94	3.13	2.59	3.00
9	Төрийн үйлчилгээний цахимжуулалт	3.05	2.90	3.03	3.10	2.56	2.95	2.94	3.05	2.61	3.00
10	Дэд бүтцийн хөгжүүлэлт	2.99	2.95	3.01	3.10	2.77	2.53	2.92	3.00	2.48	3.00
11	Үзэсгэлэн худалдаа	3.00	2.89	3.14	3.05	2.78	2.58	3.15	2.97	2.61	3.05
12	Сургалт зөвлөгөө	2.94	2.94	3.10	2.90	2.81	2.53	3.00	2.95	2.65	2.75
13	Чуулга уулзалт	2.83	2.80	2.92	2.70	2.60	2.37	2.79	2.49	2.55	2.78

Бондын санхүүжилт, хөрөнгө оруулалтын урамшууллын бодлого төдийлэн дэмжлэг болоогүй хэмээн аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээ, боловсруулах үйлдвэр, тээвэр, МАА, харилцаа холбооны салбарынхан үзжээ. Харин хамгийн өндөр үнэлгээ авсан дэмжлэгт Төрийн үйлчилгээний цахимжуулалтыг худалдаа, тээвэр, харилцаа холбооны салбарынхан, Төрийн байгууллагын нэг цэгийн үйлчилгээг уул уурхай, газар тариалан, үйлчилгээний салбарынхан, Үзэсгэлэн худалдааг МАА, боловсруулах үйлдвэр, аялал жуулчлал, мэдээлэл технологи харилцаа холбооны салбарынхан онцолсон байна.

4.2 Бизнесийн орчинг сайжруулах бодлого, үйл ажиллагааны хүрээнд цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

Монголын бизнесийн орчинг сайжруулах бодлого, үйл ажиллагааны хүрээнд цаашид хэрэгжүүлэх дараах арга хэмжээнүүд нэн шаардлагатай эсэхийг тодорхойлох зорилт тавин үнэлжлээ. Тоогоор илэрхийлж буй үнэлгээнд харгалзах утга нь дараах байдалтай болно.

- 1-Урт хугацаанд хэрэгжүүлэх (5-аас дээш)
- 2-Дунд хугацаанд хэрэгжүүлэх (3-5 жил)
- 3-Ойрын хугацаанд хэрэгжүүлэх (1-3жил)
- 4-Нэн яаралтай хэрэгжүүлэх (1 жилийн дотор)

Хүснэгт 4.8 Бизнесийн орчинг сайжруулах бодлогын хүрээнд цаашид хэрэгжүүлэх арга хэмжээнүүд (бүс нутгаар)

№	Арга хэмжээнүүд	Улсын хэмжээнд	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаан-баатар
1	Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих	3.52	3.52	3.52	3.61	3.63	3.41
2	Авилгалыг бууруулах	3.52	3.43	3.46	3.50	3.67	3.57
3	Татварын таатай орчин бүрдүүлэх	3.50	3.41	3.47	3.60	3.74	3.42
4	Санхүүжилт олгох	3.49	3.51	3.44	3.59	3.55	3.42
5	Барааг экспортонд гаргахад дэмжлэг үзүүлэх	3.46	3.37	3.40	3.53	3.68	3.41
6	Төрийн байгууллагын үйлчилгээг чирэгдэлгүй болгож, сайжруулах:	3.46	3.46	3.46	3.52	3.42	3.45
	1/ Төрийн байгууллагын үйлчилгээг цахимжуулах						
	2/ Төрийн байгууллагын нэг цонхны үйлчилгээг сайжруулах, нэмэгдүүлэх	3.45	3.44	3.40	3.50	3.38	3.50
7	Зөвшөөрөл лицензний тоог багасгах	3.43	3.31	3.45	3.47	3.61	3.40
8	Шинэ технологи санаачлагчийг дэмжих	3.42	3.37	3.35	3.50	3.56	3.40
9	Мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх	3.42	3.37	3.40	3.50	3.57	3.33
10	Хууль эрх зүйн орчинг сайжруулах	3.41	3.37	3.37	3.48	3.56	3.36
11	Дэд бүтцийг сайжруулах	3.40	3.43	3.34	3.47	3.60	3.30
12	Сургалт, зөвлөгөөг нэмэгдүүлэх	3.39	3.37	3.39	3.42	3.60	3.30
13	Мэргэжлийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх	3.37	3.36	3.36	3.47	3.49	3.26
14	Хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах	3.35	3.28	3.32	3.44	3.43	3.31
15	Үйлдвэр, технологийн төв байгуулах	3.35	3.38	3.26	3.44	3.56	3.26

Нийт бизнес эрхлэгчдийн хувьд Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлого, шударга бус өрсөлдөөнийг бий болгодог авилгалыг бууруулах, улмаар таслан зогсоох, татварын таатай орчин бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зэрэг бодлого арга хэмжээнүүдийг нэн яаралтай 1 жилийн дотор хэрэгжүүлэх шаардлагатайг онцолсон.

Үүнийг бүсчилж авч үзвэл Улаанбаатар хотоос бусад бүсүүдэд Үндэсний үйлдвэрлэлийг дэмжихийг хамгийн чухалсан бол Улаанбаатар хотын бизнес эрхлэгчид Авилгалыг бууруулах, Төрийн байгууллагын үйлчилгээг чирэгдэлгүй болгох арга хэмжээнүүд нэн яаралтай байгааг онцолсон байна. Тодруулбал тэдний 68,7% нь авилгалыг бууруулах, 61,2% нь төрийн байгууллагын нэг цонхны үйлчилгээг нэн яаралтай сайжруулах шаардлагатай хэмээн хариулжээ.

Баруун бүсийн хувьд 64,6% нь санхүүжилт олгох, 64,2% нь үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг нэг жилийн дотор яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн бол 50-аас илүү хувь нь үйлдвэр, технологийн төв байгуулах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, шинэ технологи санаачлагчийг дэмжих, сургалт зөвлөгөөг нэмэгдүүлэх, дэд бүтцийг сайжруулах, хууль эрх зүйн орчинг сайжруулах, авилгалыг бууруулах, татварын таатай орчинг бүрдүүлэх, барааг экспортод гаргахад дэмжлэг үзүүлэх, төрийн байгууллагын нэг цонхны үйлчилгээг сайжруулах, нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үйлчилгээг цахимжуулах зэрэг арга хэмжээнүүдийг нэг жилийн дотор яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай гэжээ.

Хангайн бүсийн хувьд 62,4% нь үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, 60,3% нь авилгалыг бууруулах, 59,7% нь зөвшөөрлийн лицензийн тоог багасгах, 58,7% нь татварын таатай орчинг бүрдүүлэх, 50-аас илүү хувь нь мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах, шинэ технологи санаачлагчыг дэмжих, сургалт зөвлөгөөг нэмэгдүүлэх, дэд бүтцийг сайжруулах, хууль эрх зүйн орчинг сайжруулах, мэргэжлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, барааг экспортод гаргахад дэмжлэг үзүүлэх, санхүүжилт олгох, төрийн байгууллагын нэг цонхны үйлчилгээг сайжруулах, төрийн байгууллагын үйлчилгээг цахимжуулах зэрэг арга хэмжээнүүдийг нэн яаралтай буюу нэг жилийн дотор хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна. Харин 50-аас доош хувийн санал авсан үзүүлэлтэд үйлдвэр, технологийн төв байгуулах хэмээн хариулсан байна.


Төвийн бүсийн хувьд 70,9% нь үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, 69,8% нь татварын таатай орчинг бүрдүүлэх, 69% нь санхүүжилт олгох, 67,1% нь төрийн байгууллагын үйлчилгээг сайжруулах, 67% нь барааг экспортод гаргахад дэмжлэг үзүүлэх, 65,5% нь авилгалыг бууруулах, 62,5% нь мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, 61,6% нь шинэ техник, технологийг санаачлагчдыг дэмжих, 60,5% нь төрийн байгууллагын нэг цонхны үйлчилгээг сайжруулах, нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үйлчилгээг цахимжуулах, 60,2% нь сургалт, зөвлөгөөг нэмэгдүүлэх, 60% нь мэргэжлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг нэг жилийн дотор нэн яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай хэмээн судалгаанд оролцогсод хариулсан байна.

Зүүн бүсийн хувьд 75,4% нь татварын таатай орчинг бүрдүүлэх, 74,1% нь үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, 73,7% нь авилгалыг бууруулах, 72,5% нь төрийн байгууллагын бусад дэмжлэг, 70,9% нь барааг экспортод гаргахад дэмжлэг үзүүлэх, 60 хувиас дээш санал авсан зөвшөөрөл лицензийн тоог багасгах, сургалт зөвлөгөөг нэмэгдүүлэх, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн орчинг сайжруулах, санхүүжилт олгох, шинэ технологи санаачлагчыг дэмжих зэрэг арга хэмжээнүүдийг нэн яаралтай нэг жилийн дотор хэрэгжүүлэх шаардлагатай болохыг онцолсон байна.

4.3 Өнөөгийн Монголын бизнесийн орчны ерөнхий үнэлгээ, бизнесийн орчинг сайжруулах чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ

Монголын бизнесийн орчны ерөнхий үнэлгээг 1-5 оноогоор (1-маш муу, 2-муу, 3-дунд, 4-сайн, 5-маш сайн) бизнес эрхлэгчдээр үнэлүүлж үр дүнг дараах графикт харуулав.

Зураг 4.5 Өнөөгийн Монголын бизнесийн орчны ерөнхий үнэлгээ



Монголын баялгыг бүтээгч хамгийн чухал субъект болох бизнес эрхлэгчид үйл ажиллагаа явуулж буй орчноо 2.47 буюу “бизнес эрхлэх тааламж муутай орчин” хэмээн үнэлсэн байна. Үүнийг бүсчилж авч үзвэл Зүүн, Хангайн, Төвийн бүсийнхэн бизнесийн орчноо харьцангуй дунд хэмээн үнэлсэн бол Улаанбаатар хотын бизнесийн орчин хамгийн муу үнэлгээтэй байгааг бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгчид онцгой анхаарах шаардлагатай байна.

Зураг 4.6 Өнөөгийн Монголын бизнесийн орчны ерөнхий үнэлгээ (салбараар)



Хүснэгт 4.9 Бизнесийн орчныг сайжруулахад засгийн газраас нэн тэргүүнд хэрэгжүүлбэл зохих бодлого, арга хэмжээ

№	Бизнесийн орчныг сайжруулахад төрөөс нэн тэргүүнд хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ	Хариултын хувь
1	Татварын дарамтыг багасгах, оновчтой бодлогоор хөнгөлөлт үзүүлэх	28
2	Зээлийн хүүг бууруулах, зээлийн хэмжээнд уян хатан хандах, банк, санхүүгийн зээл авах процессыг хялбаршуулах, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	25.4
3	Үндэсний үйлдвэрлэгчээ дэмжих оновчтой бодлоготой байх	23.8
4	Авлига хээл хахууль, хүнд суртлыг арилгах, шударга өрсөлдөөн, эдийн засгийн таатай орчинг бий болгох	20.6
5	Тогтвортой, алсын хараатай залгамж холбоотой төрийн бодлого явуулах, сайдууд болон төрийн боловсон хүчнийг сонгохдоо салбарын мэдлэгтэй, мэргэжлийн хүнийг чадвараар шалгаруулж томилдог байх, төрийн байгууллагууд хоорондын уялдаа холбоог сайжруулж, шат дамжлагыг багасгах, цахимжуулах, боловсон хүчнийг чадавхжуулах	20.4
6	Санхүүжилтийн эх үүсвэрийг (Хөрөнгийн зах зээл) нэмэгдүүлэх, гадны хөрөнгө оруулалт, олон улсын зээл санхүүжилт татах	15
7	Ядуурлыг бууруулж, ажлын байраар хангах (Дундаж орлоготой иргэдийн тоог нэмэгдүүлэх)	14.4

8	Дэд бүтэц, түүний дотор орон нутгийн авто замыг сайжруулах, хот төлөвлөлтийг оновчтой хийх	14.2
9	Хууль эрх зүйн тогтвортой бодлогыг хангах, хэрэгжүүлэх (засгийн газар солигдох бүр өөрчлөгдөхгүй байх) Жижиг дунд ААН-н НӨАТ, ХХОАТ, Байгууллагаас төлөх НДШ-н хувь хэмжээг бууруулж өгөх	13.8
10	Барааг экспортонд гаргахад дэмжлэг үзүүлэх, нэр төрлийг нэмэгдүүлэх (Мах экспортлох), Малын гаралтай бүтээгдэхүүний үнэ өсгөх, экспортонд мах болон бусад малын гаралтай бүтээгдэхүүнийг гаргах	13,3
11	Тендерийн ил тод, шудрага байдал, тусгай зөвшөөрлийг үнэн бодитойгоор олгох, мэдээллийн ил тод байдал	12.9
12	Мөнгөн тэмдэгтээ үнэлж, металаар баталгаажуулж гадны валютын хараат байдлаас гарах, валютын ханшыг тогтвортой байлгах	12.4
13	Орон нутагт төслийн байгууллагын үйлчилгээг сайжруулах, зөвлөгөө авах /бизнес эрхлэгчдийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт олон хэлбэрээр зохиох/	12
14	Дотоодын үйлдвэрийг дэмжиж ижил төстэй бүтээгдэхүүний импортын бүтээгдхүүнд квот тогтоож хаах оруулж ирэхгүй байх, татварын хэмжээг нэгдүүлэх	11.5
15	Томоохон төслүүдийн ТЭЗҮ ба зураг төсөл, лабораторийн шинжилгээг гадаадад хийлгэхэд үнийн дүнгээс 20% татвар авдгийг болиулах.	11.4
16	Зөвшөөрөл лицензийн тоог багасгах	11.3
17	Гадаад харилцааг хөгжүүлэх	11.3
18	Хөдөө аж ахуй руу чиглэсэн бодлого, хоршоодыг, тэр дундаа МАА-н хоршоодыг дэмжсэн бодлого	10.2
19	Хувийн өмчид соёлтой хандах, төрийн албан хаагчдын харилцааг сайжруулах	10.2

Судалгааны нээлттэй асуултад хариулсан бизнес эрхлэгчдийн 28% нь татварын дарамтыг багасгах, оновчтой бодлогоор хөнгөлөлт үзүүлдэг байх, 25,4% нь зээлийн хүүг бууруулах, зээлийн хэмжээнд уян хатан хандах, банк, санхүүгийн зээл авах процессыг хялбаршуулах, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, 23,8% нь Үндэсний үйлдвэрлэгчээ дэмжих оновчтой бодлоготой байх, 20,6% нь Авлига хээл хахууль, хүнд суртлыг арилгах, шударга өрсөлдөөн, эдийн засгийн таатай орчинг бий болгох, 20,4% нь тогтвортой, алсын хараатай залгамж холбоотой төрийн бодлогыг явуулах, сайдууд болон төрийн боловсон хүчнийг сонгохдоо салбарын мэдлэгтэй, мэргэжлийн хүнийг чадвараар нь томилдог байх, төрийн байгууллагууд хоорондын уялдаа холбоог сайжруулж, шат дамжлагыг багасгах, цахимжуулах, боловсон хүчнийг чадавхижуулахад чиглэгдсэн бодлогыг төрөөс нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай болохыг онцолсон байна.

Монголын бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг гадаад зах зээлд нэвтрүүлэх, улмаар үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлд төрөөс ямар санаачилга, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлбэл зохилтой талаар нээлттэй асуултаар судалж үзэхэд асуултад хариулагсдын 27.4% нь үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, үүний дотор ЖДҮ, орон нутгийн компаниудыг дэмжих тусгайлсан бодлогыг хэрэгжүүлэх, импортын бараанаас хамгаалах, 25.2% нь татвараар урамшуулах бодлогыг хэрэгжүүлэх, гаалийн татварыг бууруулах, хилийн хяналт шалгалтыг багасгах, 21.9% нь экспортыг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх, үүнд барааг экспортод гаргахад шинжилгээ судалгааг үнэ төлбөргүй болгох, шаардлагатай бичиг баримтын тоог багасгах, газар тариалан, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг экспортод гаргахад онцгойлон дэмжлэг үзүүлэх, 20% нь гадаад харилцааг өргөжүүлэх, худалдаа бизнесийн гэрээ хэлцэл хийх /засгийн газрын оролцоотой, төрөөс батлан даах/, олон улсын хамтын ажиллагааг дэмжих, хөрш орнуудыг татваргүй болгох, татварын тарифын таатай бодлогыг хэрэгжүүлэх нэн шаардлагатай хэмээн бизнес эрхлэгчид саналаа өгчээ.

Хүснэгт 4.10 Бизнес эрхлэгчдийн гадаад зах зээлд гарахад төрөөс дэмжих бодлого

№	Бизнес эрхлэгчдийн гадаад зах зээлд гарахад төрөөс хэрэгжүүлбэл зохих санаачлага, арга хэмжээ	Эзлэх хувь
1	Үндэсний үйлдвэрлэл дэмжих, үүний дотор ЖДҮ, орон нутгийн компаниудыг дэмжих тусгайлсан бодлогыг хэрэгжүүлэх, импортын бараанаас хамгаалах	27.4
2	Татвараар урамшуулах бодлогыг хэрэгжүүлэх, гаалийн татварыг бууруулах, хилийн хяналт шалтгалтыг багасгах	25.2
3	Экспортын дэмжих бодлогыг хэрэгжүүлэх, үүнд барааг экспортод гаргахад шинжилгээ судалгааг үнэ төлбөргүй болгох, шаардлагатай бичиг баримтын тоог багасгах, газар тариалан, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг экспортод гаргах дэмжлэгийг үзүүлэх	21.9
4	Гадаад харилцааг өргөжүүлэх, худалдаа бизнесийн гэрээ хэлцэл хийх (засгийн газрын оролцоотой, төрөөс батлан даах), олон улсын хамтын ажиллагааг дэмжих, хөрш орнуудыг татваргүй болгох, татварын тарифын таатай бодлогыг хэрэгжүүлэх	20
5	Санхүүгийн дэмжлэг үзүүлэх (хөнгөлөлттэй зээл, тусламж, зээлийн уян хатан бодлого)	19.4
6	Яам, агентлагууд нягт уялдаатай ажиллах, ажилтнуудын чадавхийг сайжруулах (засгийн газрын бүх үе шатанд нэг л шаардлага тавих) мэдээллийг хүртээмжтэй болгох	16.4
7	Бүтээгдэхүүний хөгжүүлэлт дээр дэмжлэг авах, төрөөс батлан даах, IT-Техник сайжруулах	14.7
8	Хууль эрхзүйн таатай орчин бүрдүүлэх	13.2
9	Түншлэгч олох (өөр орны адил төстэй бизнес эрхэлдэг хүмүүстэй туршлага солилцох, зах зээлийг нь олж өгөх)	13.1
10	Зах зээлийн шударга өрсөлдөөн бий болгох, чөлөөт өрсөлдөөн	12.9
11	Дотоодын эдийн засаг, бизнесийн орчинг сайжруулах, татварын хөнгөлөлт (ААН-н үйл ажиллагаагаа эхлэхэд эхний 3-5 жилд татвар авахгүй байх)	12,9
12	Малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих (гадаад зах зээл дээр борлуулах)	12.7
13	Төсөл хөтөлбөр боловсруулах (ноос хөөвөр угаах угаалгын үйлдвэр, боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлэх, хүнсний үйлдвэрлэлийг дэмжих)	11.8
14	Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	11.6
15	Ложистик үйлчилгээ явуулах	11.5
16	Дэд бүтцийг сайжруулах (Зам харилцаа-Цехэ-Нарийн сухайтны төмөр зам)	11.3
17	Зөвшөөрөл лиценз олгоход дэмжих	11.2
18	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн лаборатори байгуулах	11.2
19	Инновацийн ногоон хөгжлийн төслийг дэмжих, эрдэм шинжилгээний байгууллагуудтай холбож өгөх	10.9
20	МҮХАҮТ-н үйл ажиллагааг маш сайн дэмжиж ажиллах	10.4
21	Утаагүй Улаанбаатар төсөлд дэмжлэг үзүүлэх	10.3

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Монголын бизнесийн орчинд нөлөөлөх хүчин зүйлсэд ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийж, бизнесийн орчныг сайжруулахад нэн тэргүүн хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлохыг гол зорилгоо болгосон энэхүү судалгааг ерөнхийлөн дүгнэж үзвэл:

- ✓ Хүн амын бодит худалдан авах чадвар, түүний бууралт нь Монголын бизнесийн орчинд хамгийн сөргөөр нөлөөлж буй хүчин зүйл бөгөөд түүний дараах хүчин зүйлс нь засаглал, хууль эрх зүйн хүчин зүйлс, тодруулбал засгийн газрын үйл ажиллагаанаас ихээхэн хамааралтай санхүүгийн зах зээл, татварын орчин, бизнесийн эрх зүйн орчин зэрэг үзүүлэлтүүд нь туйлын хангалтгүй хэмээн үнэлэгдсэн байна. Эдгээрээс хамаарч бизнесийн орчин бүхэлдээ муу үнэлгээг авсан. Өөрөөр хэлбэл эдийн засагт тохиолдож буй аливаа хямралын шалтгаан нь засаглал, хууль эрх зүйн хүчин зүйлээс шууд хамааралтай байна.
- ✓ Бизнесийн орны үнэлгээ нь бүс нутгаар ихээхэн ялгаатай байна. Төвийн бүсийн аймгуудын бизнесийн орчны үзүүлэлтүүд нь бусад бүс нутгуудтайгаа харьцуулахад аль ч талаараа илүү таатай гэж үнэлэгдсэн бол нийслэлийн бизнес эрхлэгчид бизнесийн орчноо байгууллагын дотоод үйл ажиллагаанаас бусад үзүүлэлтүүдээр хамгийн таагүй хэмээн үнэлсэн.
- ✓ Монгол Улсад шинээр бизнес эрхлэхэд хөрөнгийн эх үүсвэр болон бизнес эхлүүлэх зардал хамгийн их хүндрэл үүсгэдэг ба эдгээр үзүүлэлт нь Хангай, Улаанбаатар, Баруун бүсүүдэд хамгийн муу байна. Түүнчлэн судалгаанд оролцсон нийт жижиг, дунд ААН-ийн 90 орчим хувьд нь санхүүжилттэй холбоотой хүндрэл их тулгардаг гэж хариулсан. Эдгээр хүндрэлийг бууруулахад бизнесийн төслийн үр ашигтай байдалд үнэлгээ хийж (барьцаа хөрөнгө шаардах бус), бага хүүтэй зээлийг урт хугацаагаар олгох нь чухал ач холбогдолтой юм.
- ✓ Бизнес эрхлэхэд татварын орчин маш их хүндрэл учруулдаг ба татварын эрүүл таатай орчныг бүрдүүлэхэд төрөөс анхаарч, татварын хувь хэмжээний шатлалыг дахин нягталж үзэх, шинээр эхэлж буй бизнесийг эхний жилүүдэд татвараас чөлөөлөх бодлогыг хэрэгжүүлэх нь чухал болно.
- ✓ Гадаад худалдаа эрхлэхэд тээвэрлэлтийн зардал болон цаг хугацаа, Мэргэжлийн хяналтын дүгнэлт авах процесс хамгийн их хүндрэл үүсгэдэг ба Баруун болон Хангайн бүсүүдэд тээврийн дэд бүтцийг нэн түрүүнд хөгжүүлэх; гадаад худалдааны бичиг баримтын бүрдүүлэлтийг нэг цэгийн үйлчилгээнд оруулах, цахимжуулах; хил, гааль дээрх хяналтын тоног төхөөрөмж, лабораторийн болон хил нэвтрэх чадавхийг нэмэгдүүлэх шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- ✓ Бизнес дэмжлэг үзүүлж буй субъектүүдээс хамгийн сайн үнэлэгдсэн нь МҮХАҮТ, арилжааны банкууд буюу бизнест үзүүлж буй дэмжлэгийн зэргийг дунд гэж үнэлсэн байхад төрийн байгууллагууд бизнест дэмжлэг муу үзүүлдэг хэмээн үнэлэгдсэн. Бизнесийн дэмжлэг үзүүлдэг дээрх субъектүүдийн дэмжлэг үзүүлж буй эсэх болон цаашид дэмжлэг нь бизнест хир чухал болохыг салбараар авч үзэхэд худалдаа, МАА, газар тариалан, харилцаа холбооны салбарынхны хувьд арилжааны банкууд; үйлчилгээ, аялал жуулчлал, боловсруулах үйлдвэр, барилга, тээврийн салбарт МҮХАҮТ; уул уурхайн салбарын хувьд Засгийн газар хамгийн их дэмжлэг үзүүлдэг субъектээр нэрлэгдсэн бол цаашид Засгийн газар, Орон нутгийн засаг захиргааны дэмжлэг ихээхэн хэрэгцээтэй хэмээн дийлэнх салбарын бизнес эрхлэгчид үзэж байна.
- ✓ Байгууллагын бизнесээ өргөжүүлэн хөгжүүлэхэд хамгийн ихээр саад болдог төрийн байгууллагыг бүсийн ялгаагүйгээр Татварын байгууллагыг нэрлэсэн ба тэдний мэргэжилтнүүдийн харилцаа муу (судалгаанд оролцогсдын 24.7%), авилга хээл

хахууль (21.3%) нь бизнест хамгийн ихээр саад болж байна хэмээн судалгаанд оролцогсад үзсэн. Татварын байгууллагын дараа мэргэжлийн хяналтын байгууллагыг бизнест саад болдог хэмээн улсын хэмжээнд болон баруун бүсээс бусад бүсэд үзсэн бөгөөд тус байгууллагын мэргэжилтнүүдийн харилцаа муу (27.6%), авилга хээл хахууль (23.4%)-ийг хамгийн их саад болж буй хүчин зүйлээр нэрлэсэн байна. Салбараар авч үзвэл худалдаа, үйлчилгээ, боловсруулах үйлдвэр, барилга, газар тариалан, харилцаа холбооны салбарынхан Татварын байгууллагыг, тээвэр, мал аж ахуй, аялал жуулчлалын салбарынхан Мэргэжлийн хяналтын байгууллагыг, харин уул уурхайн салбарынхан Яам, тамгын газрыг бизнест саад ихээр учруулдаг байгууллагаар тодотгосныг төр засгаас онцгой анхаарах шаардлагатай.

- ✓ Бизнесийг дэмжих бодлогын хүрээнд сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь бизнест дэмжлэг болсон эсэхийг судалж үзэхэд төрийн байгууллагын нэг цэгийн үйлчилгээ, төрийн үйлчилгээний цахимжуулалт, үзэсгэлэн худалдаа, дэд бүтцийн хөгжүүлэлт, сургалт зөвлөгөө зэрэг нь бизнест дэмжлэг болж чадсан хэмээн бүх бүсэд ижил үзсэн буюу нийт судалгаанд оролцогсдын 32-37% нь дэмжлэг болсон, 20 орчим хувь нь сайн дэмжлэг болсон, 10-18% нь маш сайн дэмжлэг болсон гэжээ. Түүнчлэн чуулга уулзалт, татварын хөнгөлөлт, НӨАТ-ын буцаан олголт, Ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, зарим барааны импортын гаалийн тарифыг өсгөсөн зэрэг нь бизнест тодорхой хэмжээнд эерэг дэмжлэг болж чадсан байна. Харин эдгээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс хамгийн өндөр өртөгтэй Бондын санхүүжилт нь хамгийн бага үнэлгээг авсан буюу бизнест бага дэмжлэг болсон хэмээн судалгаанд оролцогсад үзсэн. Цаашид өмнө хэрэгжүүлсэн бодлого шийдвэрийн бодит үр дүн, нөлөөллийг судлан шинжилж дүгнэлтэд үндэслэн дараагийн алхмуудыг хийдэг байх шаардлагатай.
- ✓ Монголын бизнесийн орчинг сайжруулах бодлого, үйл ажиллагааны хүрээнд цаашид хэрэгжүүлэх дараах арга хэмжээнүүд нэн шаардлагатай эсэхийг тодорхойлоход нийт бизнес эрхлэгчдийн хувьд Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлого, шударга бус өрсөлдөөнийг бий болгодог авилгалыг бууруулах, улмаар таслан зогсоох, татварын таатай орчин бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зэрэг бодлого арга хэмжээнүүдийг нэн яаралтай 1 жилийн дотор хэрэгжүүлэх шаардлагатайг онцолсон.
- ✓ Монголын баялгыг бүтээгч хамгийн чухал субъект болох бизнес эрхлэгчид үйл ажиллагаа явуулж буй орчноо 2.47 буюу “бизнес эрхлэх тааламж муутай орчин” хэмээн үнэлсэн байна. Үүнийг бүсчилж авч үзвэл Зүүн, Хангайн, Төвийн бүсийнхэн бизнесийн орчноо харьцангуй дунд гэж үнэлсэн бол Улаанбаатар хотын бизнесийн орчин хамгийн муу үнэлгээтэй байгааг бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгчид онцгой анхаарах шаардлагатай байна.
- ✓ Одоогийн тааламж муутай байгаа орчинг хэрхэн сайжруулах боломж байгаа талаар тодруулан судлахад татварын дарамтыг багасгах, оновчтой бодлогоор хөнгөлөлт үзүүлдэг байх, зээлийн хүүг бууруулах, зээлийн хэмжээнд уян хатан хандах, банк, санхүүгийн зээл авах процессыг хялбаршуулах, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрлэгчээ дэмжих оновчтой бодлоготой байх, авлига хээл хахууль, хүнд суртлыг арилгах, шударга өрсөлдөөн, эдийн засгийн таатай орчинг бий болгох, тогтвортой, алсын хараатай залгамж холбоотой төрийн бодлогыг явуулах, сайдууд болон төрийн боловсон хүчнийг сонгохдоо салбарын мэдлэгтэй, мэргэжлийн хүнийг чадвараар нь томилдог байх, төрийн байгууллагууд хоорондын уялдаа холбоог сайжруулж, шат дамжлагыг багасгах, цахимжуулах, төрийн боловсон хүчнийг чадавхижуулахад чиглэгдсэн бодлогыг төрөөс нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай болохыг онцолсныг асуудал хариуцсан холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд энэ чиглэлд анхаарч ажиллах шаардлагатай.



Хаяг:

**Бодлого, судалгаа хөгжлийн газар,
Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим,
МҮХАҮТ-ын байр, М.Гандигийн гудамж, 15-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот 17011, UB Post – 101011001**

Утас: +976-11-310619

Факс: +976-11-324620

e-mail: policy@mongolchamber.mn, www.mongolchamber.mn

